

“ГҮНЗГИЙ МЭД”

MONGOLIAN ECONOMY

2015 оны 03 сар, №05 (084)

www.mongolianeconomy.mn

ЭДИЙН ЗАСАГ

СТЭНД БАЙ ХӨТӨЛБӨРИЙГ БИШ, МЕГА ТӨСЛҮҮДИЙГ
СОНГОЛОО

ЕРТӨНЦ


ХУУЧИН ХУВЦАСНЫ ЭЦСИЙН ЗОГСООЛ

БИЗНЕС

Ч.МЭРГЭН: СОРЬСОН БОЛОМЖ, ӨНДӨР ХАРИУЦЛАГА

Эмэгтэйчүүдийн эсрэг “далд хуйвалдаан” эдийн засгийн өсөлтөд нөлөөлж байна

ОУВС-гийн захирал Кристин Лагард



NEW DISCOVERY SPORT

ADVENTURE.
IT'S IN OUR DNA.



ABOVE & BEYOND

START YOUR ADVENTURE

240 морины хүчтэй хөдөлгүүртэй
2500 кг ачааг чирэх хүчин чадалтай
Хурд авалт 0-100 хүртэл 8 секунд
Шатахуун зарцуулалт 8-12 литр
5 төрлийн шилжилттэй, 9 шатлал бүхий хурдны хайрцагтай



Вагнер Ази Автомотив ХХК

Нарны зам 55/1, Тэвэрчдийн гудамж, 14253, Сүхбаатар дүүрэг

www.waa.mn

Утас: 99108368, 99108386, 99118301, 99118375





МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН 2015

Монголын эдийн чуулган жил тутмын арга хэмжээ дөрөвдүгээр сарын 2-3-нд Төрийн ордонд зохион байгуулагдах гэж байгааг дуулгахад таатай байна. Зургаа дахь удаагийн чуулган “Итгэлцэл” уриан дор явагдах ба чуулганы зорилго нь эрдэмтэн мэргэд, судлаачид, шийдвэр гаргагчид, төр хувийн хэвшил, олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцуулж Монгол Улсын хөгжлийн талаар бүтээлч, оновчтой хэлэлцүүлэг өрнүүлэх юм.

Оролцогчдод төрийн дээд албаныхан, салбарын голлох мэргэжилтнүүд, бизнесийн салбарын тэргүүлэгчидтэй харилцаа холбоо тогтоох, эдийн засаг, бизнесийн талаарх бодлого, хууль дүрмийн талаарх чухал мэдээлэл авах өргөн боломж олгодгоороо бусад арга хэмжээнүүдээс ялгарах давуу талтай.

Цахим бүртгэл: <http://meforum.mn/register>

Монголын эдийн засгийн форум ТББ
«Сан бизнес центр», 9-р давхар, Б өрөө
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
Улаанбаатар, Монгол Улс
Утас: 976-11-321051
Email: info@meforum.mn





Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:
Д.Бэхбаяр / 9999-4248
Үүсгэн байгуулагч, Орлогч эрхлэгч:
И.Отгонжаргал / 8800-6228
СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:
Б.Үүрийнтуяа
Англи хэлний редактор:
Ийланд Роберт Мэнн
ВЭБ РЕДАКТОР:
Б.Энхцэцэг
Сэтгүүлчид:
Б.Энхцэцэг
А.Бүрэнжаргал
Г.Орхон
Ц.Элбэгсайхан

Маркетингийн менежер:
Д.Баранжав / 9409 2904
Б.Наранцогт / 9409 2905

ХАЯГ

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг.
I хороо, Энхтайвны өргөн чөлөө.
Экспресс товер 11 давхар 1101 тоот
15160 Улаанбаатар, Төв шуудан,
ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn
Утас/Факс: 976 - 7011 5476
“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:

“Интер ном”
“Цэцэг төв”
“Минж плаза”
“Алтантүлхүүр” номын дэлгүүр
“Номин” супермаркетин бүх салбар
“Макс” супермаркетин бүх салбар
“Фреско” супермаркет
BTSI супермаркет
“Аз орчлон” номын дэлгүүр
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг
“Гранд Плаза” дахь супермаркет
“Мир” номын дэлгүүрийн
“Grand plaza”
“Metro mall”
“Sky” супермаркет
“Улаанбаатар” их дэлгүүр
“Max mall” дэх салбарууд

Монголын сэтгүүлчдийн эвлэлийн “2013
оны Шилдэг сэтгүүл”

Монголын бизнесийн зөвлөлийн
“Бизнесийн салбарыг дэмжигч хэвлэл
мэдээллийн байгууллага - 2012”
МҮХАҮТ-ын “2011 Оны Онцлох Хэвлэл”



РЕДАКЦИА
ЗАХИАЛБАЛ
ХҮРГЭЛТ
ҮНЭГҮЙ

БОРЛУУЛАЛТЫН ҮНЭ

18.000₮

ЗАХИАЛГЫН ҮНЭ

НЭГ ДУГААР	15.000₮
УЛИРАЛ /6 дугаар/	90,000₮
ХАГАС ЖИЛ /12 дугаар/	180.000₮
ЖИЛ /24 дугаар/	360.000₮

- 8 Монгол Улс өөрөө өөрийнхөө нүүрийг толинд хар я
- 13 Стэнд бай хөтөлбөрийг биш, мега

“P14



төслүүдийг сонголоо

- 16 Морин жилийн сүүлэн дээр

- 18 Далд хуйвалдаан эдийн засгийг “дарлаж” байна
- 20 Эмэгтэйчүүдийн сэтгэлгээний хувьсал
- 23 Бизнесийн түршлага сууж, хүнд үеэ давсан эмэгтэй

“P24



- 28 Эрхээ хамгаалах өдрийн эргээд харах үр дүн

- 32 Төсвийн орлогод үзүүлэх хувь хамгийн доод хэмжээнд хүрнэ
- 34 “Эрдэнэс Монгол”-ын шинэ удирдлагыг юу хүлээж байна вэ?

е

- 36 Хөгжихөөр илгээсэн мессеж хүссэн дүн авчирсангүй
- 37 Хуучин хувцасны эцсийн зогсоол

“P37



БИЗНЕС

- 38 Ч.Мэргэн: Сорьсон боломж, өндөр хариуцлага
- 40 Хувьцаа эзэмшдэг бол хуралдаа суугаарай

- 44 Хил давсан гээд хамаагүй гэж болохгүй

Манай сайт руу зочилж, өдөр бүр эдийн засаг, бизнесийн талаар шинэ мэдээлэл аваарай.

ЭДИЙН ЗАСАГЧДЫН БУЛАН

MongolianEconomy.mn/ дээр доорх **улаанаар тодруулсан** тэмдэгтүүдийг нэмээд холбогдох нийтлэлийг уншаарай.



Б.Эрдэнэбат

Мэдлэг бол хүч ба Өвөр Монголоос төрсөн сэтгэгдэл

Өвөр Монголын дөрвөн

том их сургуульд очиж урилгаар лекц уншив. Сайхан монголчуудтай танилцлаа. Монгол улсад Солонгосын соёлын нөлөө их болж байгаа. Харин Өвөр Монголд Монгол улсынх маш их байдаг юм байна. Бидний уран зохиол, урлаг - mn/p/7176



Ө.Ганзориг

Хөшүүрэг

Хүний үйл хөдлөлийг удирддаг Эдийн засгийн ба Философийн

хөшүүргүүдийг өнөөдөр авч үзье. Нэг талдаа Хүн буруу зүйлд амархан уруу татагддаг, залхуу, амин хувиа хичээсэн, аймхай амьтан. Гэхдээ хүнийг эдгээр зан чанарууд нь нээлт хийлгэж -

mn/p/7268



Б.Дөлгөөн

Хямралын гарц бол экспорт

2015 оны босгон дээр Ерөнхий сайд

Ч.Сайханбилэг хэлсэн үгэндээ Монголын эдийн засаг хямарлаа гэдгийг хүлээн зөвшөөрлөө. Эдийн засгийн тодорхойлолтын хувьд хоёр улирал дараалан эдийн засаг агшихыг хямрал гэж нэрлэдэг. Гэтэл 2014 оны арваннэгдүгээр сарын байдлаар -

mn/b/7292

Монголд

Ипотек



Банкууд энэ оны нэгдүгээр сард нийт 1280 зээлдэгчид 75.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгожээ. Мөн зээл хүсэгчдийн тоо 67233-т хүрчээ. Тайлант хугацааны эцэст зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт өмнөх сартай харьцуулахад 3.3 хувиар, өмнөх оны мөн үеэс 92.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй гарсан байна. Тус хугацаанд зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээл 2.1, чанаргүй зээл 0.5 хувийг эзэлж байгаа талаар Монголбанкны нэгдүгээр сарын ипотекийн зээлийн тайланд дурьдсан байна. Нийт зээлийн хэмжээг дундажлан үзвэл нэг зээлдэгчид 58.6 сая төгрөгийн зээл олгожээ. Харин эргэн төлөгдсөн хэмжээ нэгдүгээр сард 22.5 тэрбум төгрөг байгаа нь өмнөх сараас 14.5 хувиар буурсан, өнгөрсөн оны мөн үеэс 3.7 хувиар өссөн үзүүлэлт аж.

Түүхий эд



Зэс, нүүрс гээд уул уурхайн түүхий эдийн зарим бүтээгдэхүүний үнэ энэ онд сайнгүй байх төлөвтэй байгааг шинжээчид хэлж

буй. Тодруулбал, төмрийн хүдэр тонн нь 65 ам.доллар, хүдэр 80 ам.доллар, цэвэр зэс 6500 орчим ам.доллар байх таамаг дэвшүүлээд байгаа. Харин алтны үнэ энэ жил нэмэгдэх төлөвтэй байна. Нэг унци алт 1185 ам.доллар байгаа юм. Шинжээчдийн үзэж буйгаар олон улсад алтны үнэ эдийн засаг сайнгүй үед өсч, тогтворжих үед буурах хандлагатай байгааг онцлоод байна.

Судалгаа

“Price Waterhouse and Coopers” компаниас Дэлхийн нэр нөлөө бүхий 100 CEO нараас авсан судалгааны дүнгээс үзэхэд дэлхийн эдийн засгийн эрх мэдэл Ази руу шилжих болно гэсэн сонирхолтой дүн гарсан байна. Захирлуудын үзэж буйгаар энэ онд эрсдлээс илүү боломж өндөртэй жил байх аж. Тухайлбал, оролцогчдын 61 хувь нь энэ онд бизнесийн салбарт илүү боломж бий гэсэн бол 59 хувь нь эрсдэл ихтэй жил гэж харжээ. Түүнчлэн захирлуудын хамгийн их санаа зовоож буй асуудлыг тодруулахад 78 хувь нь хэтэрхий их дэг журам тогтоосон, эрх чөлөөгүй байдал нэн тэргүүнд асуудал болж байна гэжээ. Дараагийн асуудал бол голлох салбаруудад туршлагатай, чадварлаг мэргэжилтэн ховор байна гэж 73 хувь нь үзсэн байна.

Амьжиргааны түвшин

Жил бүр шинэчлэн тогтоодог Хүн амын амьжиргааны доод түвшинг танилцууллаа. Энэ оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд амьжиргааны доод түвшин 185400 төгрөг болж өсчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад



16400 төгрөгөөр өссөн үзүүлэлт. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлохдоо хүн амын нас, хүйсийн ангиллаар бүсэд хувиарладаг. Түүнчлэн олон улсын байгууллагуудад нийтлэг мөрдөж буй аргачлалыг өөрийн орны онцлог нөхцөлтэй уялдуулан гаргадаг юм байна.

Хөрөнгийн зах зээл

Монголын Хөрөнгийн бирж өнгөрсөн сарын эцсийн байдлаар 209 тэрбум гаруй төгрөгийн орлого олж, 152 тэрбум төгрөгийн



зардал гаргасан талаар шилэн дансны мэдээлэлдээ дурьджээ. Ингэснээр 57 сая төгрөгийн ашигтай төдийгүй хоёр сар дараалан амжилттай ажилласан байна. Үүнд Засгийн газрын үнэт цаасны зах зээлийн арилжааг дөрвөн удаа зохион байгуулж, 266 мянган ширхэг үнэт цаасыг 26.6 тэрбум төгрөгөөр, 1.3 мянган ширхэг үнэт цаасыг 124.9 сая төгрөгөөр арилжаалж, нийт 27.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн нь голлон нөлөөлжээ.

Банк, санхүү

20 сая хүртэлх төгрөгийн хадгаламжтай иргэд, аж ахуйн нэгж тухайн банк дампуурахад нөхөн төлбөрөө 100 хувь буцаан авах боломжтой болжээ. Хадгаламжийн даатгалын корпораци 2003 онд үйл ажиллагаагаа явуулж

эхэлснээр дээрх боломж бүрдсэн аж. Тус корпораци Монголбанкнаас татан буулгах шийдвэр гаргасан банкинд хадгаламжтай иргэдэд нөхөн төлбөр өгөх юм байна. Энэ нь арилжааны банкуудын эрсдлийг бууруулж, банкинд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой аж. Ингэснээр хадгаламж эзэмшигчдийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгааг Хадгаламжийн даатгалын корпорациас мэдээллээ. Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа 13 арилжааны банк цар хүрээнээсээ хамаарч жилдээ нэг тэрбум хүртэлх төгрөгийн хураамжийг уг корпорацид төвлөрүүлдэг байна.

Уул уурхай

Тавантолгойн төслийн хөрөнгө оруулалт, концессийн болон хамтын ажиллагааны гэрээ хэлцлүүд үндсэндээ шийдэгдсэн талаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар мэдээллээ. Харин зарчимын хоёр, гурван асуудал дээр талууд дээд байгууллагуудтай ярилцах, зөвшилцөх шаардлага үүссэн аж. Тодруулбал, Хятадын төрийн өмчит “Чалко” компаниас Зүүн Цанхийн нүүрсийг барьцаалж зээлсэн 350 сая ам.долларын өрнөөс 150 сая нь төлөгдөөгүй бөгөөд энэ өрийг Засгийн газраас тавьсан шаардлагын дагуу стратегийн хөрөнгө оруулагчид төлөх учиртай аж. Одоогийн байдлаар “Чалко”-тай холбогдох асуудлаар тохиролцоонд хүрээгүй байгаа юм. Манай улс 2011 онд тус компанитай

байгуулсан гэрээнд өрөө төлж дуусах хүртэл Зүүн Цанхийн нүүрсийг тус компанид зуун хувь нийлүүлэх, төлж дууссаны дараа таван жил тус ордоос олборлосон нүүрснийхээ 80 хувийг Чалкод өгөхөөр тусгажээ. Энэ гэрээг зөрчвөл Монгол Улсын Засгийн газар Арбитрын шүүхэд дуудагдахаар байгаа аж. Гэвч аль болох ийм байдалд хүргэхгүйн тулд талууд энэ талаар нэлээд нухацтай ярилцаж байгааг ажлын хэсгийнхэн учирлав.

Дэлхийд

Гилдфорд Монгол руу ойртож байна



“Mining Weekly”-ийн мэдээлснээр Австралийн уул уурхайн олборлогч компани “Гилдфорд Коул” Монгол дахь үйл ажиллагаандаа ойртох үүднээс Сингапур улс руу компаниа шилжүүлэх бололтой. Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Гилдфорд” энэ гуравдугаар сарын эхээр Сингапурын Хөрөнгийн биржид давхар эсвэл дан дансны бүртгэлтэй болохоор зэхэж байгаа аж. Ингэснээр компанийнхаа үйл ажиллагаа болон хувьцаанд илүү ойртох юм. Тус компанийн хувьцааны дийлэнхийг Азийн хөрөнгө оруулагчид эзэмшдэг. “Гилдфорд”-ын зүгээс үйл ажиллагаагаа хянахын тулд Австрали, Монгол дахь салбаруудаа хэвээр үлдээх юм. Энэ онд тус компани гол

анхаарлаа Монголын Баруун Ноён Уулын уурхайгаас нэг сая тонн нүүрс олборлох төлөвлөгөөндөө хандуулах аж. “Гилдфорд” өнгөрсөн арванхоёрдугаар сараас олборлолт хийж эхэлсэн бөгөөд 2015 оны хоёрдугаар сараас Хятад руу нүүрс гаргаж эхэлжээ. Тус компани 2016 онд хоёр сая тонн нүүрс, 2017 онд гурван сая тонн, 2020 он гэхэд тогтвортойгоор таван сая тонн нүүрсний олборлолт хийх зорилгодоо хүрэхийн тулд Өмнөговийн төслөө өргөжүүлэхээс гадна Баруун Ноён Ууланд уурхай нээх юм. Төслийн хүрээнд дээрх ордыг 70.4 тонн нүүрсний нөөцтэй гэж тооцоолжээ.

ОХУ-д өрнөж буй эсэргүүцэл

Өнгөрсөн хоёрдугаар



сарын сүүлээр Кремлийн ойролцоо Оросын сөрөг хүчний улс төрч Борис Немцовын амийг хороосон. Түүний үхэл Оросын ард түмэн болон тус улсын ирээдүйд томоохон сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна. Гуравдугаар сарын 1-ний өдөр олон мянган эсэргүүцэгчид Немцовын хүндэтгэн жагссан бөгөөд тэд “Путингүй Орос” гэж бичсэн далбай намируулж, уриалцааж байлаа. Жагсагчид болон тэднийг дэмжигчид Немцовын аллагад Ерөнхийлөгч Владимир Путин буруутай гэж үзэж байгаа бол Засгийн газрын хэвлэл мэдээллийн алба энэхүү хэрэгт барууны

улсуудыг буруутгаж байгаа юм. Ерөнхий сайдын орлогч асан Немцовыг Кремлээс холгүй байрлах нэгэн ресторанаас гарч гэртээ харих замд нь буудан хороосон юм. Путиний Засгийн газрыг эсэргүүцэх жагсаал болохоос нэг өдрийн өмнө энэхүү аймшигт хэрэг гаржээ. Хэргийг мөрдөх хорооны мэдээлсэнээр тус хэрэг Украин эсвэл Исламын террористуудын зөрчилтэй холбоотой байх магадлалтай гэжээ. Судлаачид энэхүү аллага Путины эсрэг Оросын сөрөг хүчнүүдийг нэгтгэнэ гэж үзэж байна. Немцов Засгийн газрын үр дүнгүй ажиллагаа, хэрээс хэтэрч буй авилга болон Оросыг барууны улсуудтай харилцах харилцаанд сэв суулгасан Украинд хэрэгжүүлж буй Кремлийн бодлого зэргээр Путинийг хүчтэй шүүмжилдэг байсан юм. Гуравдугаар сарын эхээр НҮБ-ын мэдээлснээр Украины зөрчилдөөнөөс үүдэн 6000 хүн амь эрсдээд байна гэжээ.

Энэтхэг инфляцийн эсрэг Мөнгөний шинэ



бодлогынхоо хүрээнд Энэтхэгийн Засгийн газар болон Төвбанк инфляцийн эсрэг тууштай тэмцэхээр боллоо. Ингэснээр рупигийн ханш тогтворжих учиртай юм. Тус улсын Сангийн яамны мэдээлснээр Энэтхэгийн Төвбанк болон Засгийн газар 2017 оны гуравдугаар сар гэхэд

өргөн хэрэглээний барааны инфляцийг дөрвөн хувьд хүргэх зорилт тавьсан гэжээ. Эрчим хүчний импортоос хэт хараат байдал, хөдөө аж ахуйн салбарт гэнэтийн зохилт болсон, дэд бүтэц хөгжөөгүй зэргээс үүдэн хоол хүнс, өргөн хэрэглээний бараа тээвэрлэлтэд хүндрэл учрах болсон. Улмаар тус улсад инфляцийн түвшин саарсаар байгаа аж. Хүч түрэн орж ирж буй эдийн засгууд инфляцийн эсрэг бодлого явуулдаг нь нийтлэг бөгөөд үнийн өсөлт тухайн улсын ядуу иргэдэд хүндээр тусдаг аж.

Ерөнхийлөгч Берлинд

Ерөнхийлөгч

Ц.Элбэгдорж гуравдугаар сарын эхээр Берлинийг зорьсон бөгөөд айлчлалын хүрээнд Германы Канцлер Ангела Меркелтэй уулзаж, “ITB” аялал жуулчлалын үзэсгэлэнгийн нээлтэд үг хэлсэн. Хамтарсан хэвлэлийн бага хурлын үеэр Меркел хэлэхдээ “Монголын агаарын тээвэрлэгч байгууллага Германы агаарын тээврийн тэргүүлэгч компани болох “Люфтханса”-тай хамтран ажиллах талаар хэлэлцсэн” гэжээ. Тэрбээр 2011 онд Монголд айлчлахдаа дэвшүүлж байсан бараа, худалдааны гэрээ хийх сонирхолтой байгаагаа дахин тэмдэглэсэн байна. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Монголын 15 тэргүүлэгч бизнес эрхлэгчийн хамтаар Герман-Монголын бизнесийн форумд оролцсон бөгөөд Берлин хотын төвд шинээр баригдсан Монголын Элчин сайдын яамны барилгын нээлтийн ажиллагаанд оролцсон. ■



Фотог Б.Бямба-Очир

Редакцийн уулзалт

Монгол Улс өөрөө өөрийнхөө нүүрийг толинд харъя

Б. Энхцэцэг, Г. Орхон

“Mongolian Economy” сэтгүүл болон манай цахим хуудсын редакцийн уулзалт боллоо. Бид зочидтойгоо эдийн засгийн хүнд байдал, түүнээс гарах арга замыг эрэлхийлэх талаар ярилцсан юм. Редакцийн зочдоор Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч Ө.Ганзориг, “Эм Ай Эйч” группын ерөнхийлөгч Д.Жаргалсайхан, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн

багш Б.Эрдэнэбат нар уригдаж санаа бодлоо хуваалцлаа. Тэд Засгийн газрын тэргүүний бодлогыг “гал унтраах” арга хэмжээнүүд гэж үзэж байна. Компанийн захирал санхүүгээ өдөр тутам харж хянадаг шиг Засгийн газар, УИХ төсвөө танаж, халамжийн бодлогоо цэгцлэх зэрэг нь өдөр тутмын үйл ажиллагаа. Харин олон арван жилийн дараа Монгол Улс ямар түвшинд очиж, ямар

орон болохоо тодорхойлж шинэчлэл, өөрчлөлтийг хийх нь төрийн жинхэнэ бодлого хэмээн манай уулзалтын оролцогчид хэлж байна.

Бид энэхүү уулзалтаар Засгийн газрын тэргүүнийг шүүмжлэхийг хүссэнгүй. Харин өнөөдрийн Монгол Улсын үнэн төрх болоод бид хаашаа явж буй талаарх бизнес эрхлэгч, эдийн засагчдын байр суурийг сонсохыг зорив.

-Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын үүр уурхай нь юу байв, бид алдаанаасаа суралцаж чадсан уу?

-Ө.Ганзориг: /Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч/

Өөдрөг байдал харагдахгүй байна. Учир нь иргэд, бизнес эрхлэгчид, төр гээд нийгэм бүхлээрээ өөдрөг байдлыг харж чадахгүй болчихоод байна. Би бизнес талаас нь ярья. Ер нь хувь хүн, компани, улс орны хувьд эдийн засгийн шийдвэр гаргадаг, эдийн засгийн үр ашиг олдог бүтэц нь яг адилхан. Хэмжээ нь томроод байгаа болохоос адилхан бүтэцтэй. Барын сүүл байснаас батганы толгой байх нь дээр гэдэг. Хэрвээ компани зорилгоо тодорхойлоогүй бол тухайн компанийн захирал, албан тушаалтнууд компаниа тонож эхэлдэг. Улмаар компанийн ажилтан, удирдлагууд зорилго чиглэлгүй “луйварчид” болоод ирэхээр уналтын системд орно. Харин эерэг сэтгэлгээтэй нь сэтгэл санааны дарамтад орно. Ингээд ямар нэгэн амьдралын зорилгогүй болсноор зүг чигээ алддаг. Улмаар бүтээмжгүй болчихдог.

Эдийн засгийн чадавхыг хэмждэг хамгийн гол хүчин зүйл нь бүтээмж. Гэтэл америк, орос хүнтэй харьцуулахад монгол хүний бүтээмж ямар байна вэ? Цагт хэдэн хадаас хийж байгаагаар болхи хэмжиж болно. Эсвэл бид ямар хэмжээний цар хүрээтэй оюуны бүтээл гаргаж байна вэ гэдгээр хэмжиж болох юм. Одоо бүтээгдэхүүн гэдэг биет бус боллоо. Өнгөрсөн онд Тайландад Солонгосын охидын хамтлаг ирээд нэг орой дуулаад л 50 сая ам.долларын ашиг олоод явж байхыг харлаа. Энэ бол оюуны экспорт. Бид өөрсдийгөө ядуу улс гэж нэрлээд олон улсын байгууллагуудаас “гуйлга” гуйж 24 жил явсан. Ядуурлаас гаръя гэх зорилт бүхий зүйл байсан юм шиг байгаа юм. Гэхдээ логикийн хувьд ядуурлаас гаръя гэдэг зорилт тавьж ядуурлаас гардаггүй юм байна. Улс орнууд хөгжих зорилго тавьдаг. Өнгөрсөн хугацаанд бид хөгжлөөрөө дэлхийд хэддүгээр байранд очих вэ гэдэг зорилтоо огт дэвшүүлээгүй ирсэн. Тухайлбал, Швейцарь улс Үндсэн хуульдаа заасанчлан тус улсын хамгийн ядуу иргэнийг дэлхийн дундажтай харьцуулаад хөгжлөө хаана байгааг

тодорхойлж байна. Тэгэхээр юуны өмнө бид зорилго тавих хэрэгтэй. Ингэхгүй бол дэлхийн улсууд Монголыг гуравдагч орон гэж ярьж байна. Өнгөрсөн оны Эдийн засгийн форум дээр Дэлхийн эдийн засгийн байгууллагаас манай улсын хөгжлийн хөтөлбөрийг гаргасан. Энэ хөтөлбөрт “Хятад улс хөгжвөл, Хятад улс хөгжихгүй бол” гэсэн үндсэн хоёр хувилбарыг дэвшүүлсэн. Гэтэл Монгол Улсын хөгжил хэзээнээс өөр улсын хөгжлөөс хамаардаг болчихсон юм бэ. Хэзээнээс манай улсын хөгжлийн хөтөлбөрийг төрийн бус байгууллага гаргадаг болсон юм бэ. Хэзээнээс бид ийм байгууллагын гаргасан хөтөлбөрийг Төрийн ордондоо чих тавин сонсдог болов. Өнөөдөр төр үндсэн үүргээ гүйцэтгэхгүй байна. Төр зорилго, чиглэлийг тодорхойлж, түүнд хүрэх арга замыг сонгох үүрэгтэй. Ард түмэн сонгохгүй. Өнгөрсөн 24 жилийн турш төр ард түмнээр замаа сонгуулж ирлээ. Өнөөдөр ийм дүр зураг бий болоод байна.

-Д.Жаргалсайхан: /“Эм Ай Эйч” группын ерөнхийлөгч/

Хамгийн гол нь одоогийн эдийн засгийн өсөлт буурахад юу хийгээгүйгээс үүдэн ийм байдалд хүрчихэв гэдгийг бид сайн оношлох хэрэгтэй. Ингэж онолохын тулд цогцоор нь авч үзэх хэрэгтэй. Үлгэрт гардаг шиг сайн “хаан” гарч ирээд бүх асуудлыг шийдвэрлэхинэ гэж харж, хүлээх хэрэггүй. Тэр үе өнгөрсөн. Өнөөдрийн бизнесийн орчныг авч үзэхээр ийм дүгнэлтэд хүрч болохоор байна. “Тунгалаг тамир” кинон дээр цахиур Төмөр ширлүүлчихдэг шиг сүүлийн үед баялаг бүтээгчид ширлүүлчихээд байна.

Монголд эдийн засгийн эрх чөлөө алга. Олон улсын судалгаануудад Монголыг улс төрийн эрх чөлөөний хувьд нэлээн өндөр түвшинд хүрчихсэн гэж байна. Бидний дараагийн чухал зүйл бол Үндсэн хуульд заасан байдаг амьд явах эрхийн дараах эдийн засгийн эрх чөлөө юм. Энэ нь хүн өөрөө хөдөлмөрлөж, хөдөлмөрийнхөө үр шимийг бусдад хүртээх эрх чөлөө. Гэтэл эдийн засгийн эрх чөлөөгөө эдлэх эрхтэй хүмүүс нь ширлүүлчихээд байна.

Бид сүүлийн үед уул уурхайн салбарын хаялгаар орж ирсэн төсвийн орлого, эдийн засгийн өсөлтөд

“бялуурсан” байна. Бялуураад халамжийн хавтгайрсан бодлого явуулсан. Сүүлдээ элдэв янзын хуулиуд гаргасан. Ядарсан иргэдээ халамжлах ёстой гэсэн логик бий. Энэ нь зөв. Гэтэл нөгөө баялаг бүтээж байгаа хүмүүсийнхээ мөнгийг аваад халамж руу шууд өгдөг. Үүнийгээ халамжийн бодлого гээд нэрлэчихсэн. Гэтэл энэ нь эргээд ажил хийж байгаа нэгнээ хүлчихэж байгаа юм. Нөгөөтэйгүүр нэг хүний эрхийг хамгаалахын тулд нөгөө хүний эрх ашгийг хааж байна. Уг нь хоёулангийнх нь эрх ашгийг хамгаалах ёстой. Хүнд хариуцлага хүлээлгэхийн тулд хүний өмч рүү эрээ цээргүй халдаж байна. Энэ нь дээр дурьдсан хүлээс бий болсныг харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл, өнөөдрийн улс төр, эдийн засгийн байдалд бизнес эрхлэгчид дөнгөлүүлчихээд байна. Үүнээс гарах гарц нь эдийн засгийн эрх чөлөө.

-Б.Эрдэнэбат: /МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн профессор/

Манай улсын өнөөгийн байдал ямар нэг зүйлээс хараат болчихож. Манайд хэрэгжиж буй халамжийн бодлого хүмүүсийг ажил хийлгэхээргүй байдалд оруулсан гэж яриад байгаа. Хэрвээ үнэн бол хасч, танах л ёстой. Эдийн засгийг урагш авч явдаг зүйл бол бүтээмж. Энэ нь хүн болгонд бий. Тэгэхээр иргэн та өөрийн сайн хийж чадах ажлаа өмнөх жилээсээ таван хувиар илүү хийдэг болчихвол таны бүтээмж мөн адил хэмжээгээр өсч байгаа гэсэн үг. Тэгэхээр хүн бүр өөрийн бүтээмжээ таван хувиар өсгөвөл Монгол Улсын эдийн засаг энэ хувиар өснө. Монгол Улсыг уул уурхайн салбар нэлээн авч явсан. Иргэдийн бүтээмж өндөр биш байсан ч тухайн салбарын бүтээмж өндөр байх үед энэ бүтээмжийн хаялга нь хүмүүст орж ирдэг. Гэвч нэг салбараас хэт хараат байхын сул тал бий. Тухайн салбарын бүтээмж унахаар эдийн засагт сөргөөр нөлөөлдөг. Хэрвээ бусад салбарын бүтээмж өндөр байсан бол хямралыг бид ерөөсөө мэдрэхгүй байх байсан. Харамсалтай нь, өнөөдөр тийм биш байна. Улсын нийт эдийн засгийн 20 хувь нь уул уурхайн салбарын нийт ажиллах хүчний дөрвөн хувьтай тэнцдэг байв. Энэ салбар дээрх хоёр орлогоос гадна гадаадын хөрөнгө оруулалтын 50 хувийг оруулж ирдэг байсан. Үүнтэй холбоотойгоор эдийн

засгийн одоогийн байдал бий болоод байна гэж харж байна.

Уул уурхайн салбараас орж ирэх бэлэн мөнгийг тосч суугаа монголчууд бидэнд зорилго алга. Энэ зорилгыг төр, засаг ухамсарлахгүй байна. Хувийн хэвшлээ дэмжье, дэмжиж байна гэдэг ч үнэн хэрэгтээ баялаг бүтээгчид, иргэдээ дөнгөлчихөөд байна гэж зочид хэлж буй. Тэгвэл дөнгөнөөсөө салж хөгжлөө “мотордохын” тулд бид цаашид яах вэ?

- Ө.Ганзориг

Дээр үед эдийн засагт гурван нөөц байна гэж үздэг байсан бол өнөөдөр ганцхан нөөц байна гэж үзэж байгаа. Тэр бол хүн. Тэгэхээр хүн гэдэг нөөцөө хүрэх гэж байгаа зорилгодоо тааруулж бэлддэг. Үүнийг чухал арга хэмжээ гэж байгаа юм. Гэтэл өнгөрсөн 24 жилд зорилгоо тодорхойлоогүйгээс асуудал гарлаа гэдэг нь боловсрол. 1990 онд шилжихэд суурь боловсролын түвшнээрээ бид дэлхий нийтээс холгүй байсан. Мэдээж чөлөөт зах зээл, эдийн засгийн харилцааны тал дээр “нойл” байсан. Харин 24 жилийн дараа бид боловсролынхоо түвшнээр хаана очив. Бид боловсролын нөөцөө аль зүгт хөдөлгөх тухай бодох хэрэгтэй болоод байна. Өнөөдөр Монголын боловсролын системээр бэлтгэн гаргаж байгаа 160 мянган оюутанд ажил олгогчид муу дүн тавьж байна. Тэд ажил хийж, хүнтэй харилцаж чадахгүй

байна. Ийм л бүтээгдэхүүн гаргаж байна. Зорилгогүй учраас эдийн засгийн гол нөөц болох хүнээ бэлддэг боловсролын системээ хаячихсан. Бид өөрсдийгөө яагаад хэмждэггүй юм бэ. Монгол Улс өөрөө өөрийнхөө нүүрийг толинд харъя. Хүн л хэлээд байгаа болохоос биш бодитой үнэлгээ алга.

-Б.Эрдэнэбат

Эдийн засагт байгалийн баялгийн хараал гэдэг ойлголт бий. Монголын нийгэм, эдийн засгийн байдал баялгийн хараал руу явж байна. Төр, засаг уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтаас хараат болчихоод байна. Төрийн хийж чадах зүйл үүгээр хязгаарлагдаад байгаа нь эмгэнэлтэй. Байгалийн баялаг их байх тусам рент буюу хүн хөдөлмөрлөхгүйгээр ашиг олох боломж өснө. Өөрөөр хэлбэл, зүгээр сууж байгаад мөнгө олно. Удирдлагууд ингэж хөгжүүлэе гэхээс илүү яаж тэр мөнгийг авах вэ гэсэн

“ Төсөвт их өгч буй нь сайн гэх хандлага бидний хамгийн том алдаа ”



Б.Эрдэнэбат

сэтгэхүйтэй болж. Энэ нь манайд бий болоод байгаа байгалийн баялгийн хараал. Төр ард түмэнтэй татвараар холбогддог. Гэтэл дэлхийн хэмжээний уул уурхайн компани жижигхэн Монголд орж ирж, тэдний хаялага хангалттай байгаа тохиолдолд төр ард түмнээс татвар авах шаардлагагүй болж байгаа юм. Тухайлбал, Саудын Араб, Кувейт зэрэг оронд татвар огт байхгүй. Аж ахуйн нэгжийн болон хүн амын орлогын албан татвар гэж байдаггүй. Гэтэл нөгөө уул уурхайн салбараас орж ирэх орлого нь байхгүй болохоор төр өмнө нь мартсан зүйлсээ гэнэт гаргаж ирж байна. Энэ нь иргэд, аж ахуй нэгжүүдийн хувьд нэг талаас том “шок” болж байгаа.

Монгол Улс өөрийн гэсэн зорилготой болъё гэдгийн хувьд санал нэгтэй байна. Бид монгол хүний ажлын бүтээмжийг наад зах нь урд хөрш, төв Азитай харьцуулах хэрэгтэй. Үүнийг зөвхөн төр хийнэ гэхээр бас болохгүй. Монголын улс төр, эдийн засгийн талаар төрөөс ярих зүйл нь хэрхэн тэр хүмүүсийн ашиг сонирхлыг урт хугацаанд хадгалах вэ гэдэг л асуудал байна. Түүнээс биш үүнд олон нийт нэг их хамаарахгүй. Олон нийтэд тэд популизм хийнэ. Үндсэндээ Монголд хөгжих боломж алга. Учир нь Монгол бол тэдний мөнгөө хийдэг хогийн сав нь. Өөрсдийнх нь амьдрал эрс өөр байдаг. Ингээд төр, ард түмэн хоёр тасарчихаар хөгжих боломж харагдахгүй байна. Өнөөдөр улсын нийт ажиллах хүчний дөрөв хүрэхгүй хувь нь уул уурхайн салбарт ажиллаж байна. Тиймээс үлдсэн 96 хувийг яаж бүтээмжтэй болгох вэ гэдэг асуудал байна.

Эдийн засагчид ажилгүйдлийн гурван төрөл байдаг гэдэг. Бүтцийн, шилжилтийн, мөчлөгийн. Хамгийн чухал нь бүтцийн ажилгүйдэл. Эдийн засаг өөрийн онцлог бүтэцтэй. Уул уурхайн салбарын эдийн засагт тулгуурласан бүтцийн ажилгүйдэл өндөр байх магадлалтай. Монгол Улс 1992 онд 16 мянган оюутантай байсан бол өдгөө 176 мянга болсон байна. Бид тэдэнд дэлхийн хэмжээний боловсрол олгоход анхаарах хэрэгтэй.

Эдийн засаг хүндрэхээр дараагийн бүтээмж, өсөлтийн “мотор” хаанаас гарч ирэх вэ гэж хардаг. Энэ нь ажиллах хүчний чадвар, мэдлэг боловсрол. МУИС олонхын саналаар Санхүү, эдийн

засгийн тэнхимээ татан буулгасан. Уг нь үүн дээр удирдлага шийдвэр гаргах ёстой. Ерөнхий сайд нь хүртэл иргэдээс асууж байх жишээтэй. Энэ нь бид буруу системээр яваад байгааг харуулж байгаа юм. Манайхан мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгоно гэж ярьдаг. Гэтэл энэ мэдлэгийн салбарт ямар хүмүүс ажиллаад байна вэ, ямар мэдлэгтэй хүмүүс боловсрол олгож байна гэдгийг бодохоор бид өөрсдийгөө энэ асуудлаас гаргах ёстой болохыг олж харна. Гадаадад ажиллаж, амьдарч байгаа чадварлаг боловсон хүчнээ эх орондоо авч үлдэх талаар бид бодохгүй байна.

-Д.Жаргалсайхан

Монголчууд бидэнд сүүлийн үед тулгараад байгаа хамгийн том аюул бол бүх зүйлийг мөнгөөр хэмждэг болчихоод байна. Энэ нь туйлын муу. Мөнгө их өгч байгаа бол сайн. Төсөвт их юм өгч байгаа бол сайн гэсэн хандлага буруу. Бидний хамгийн том алдаа эндээс гарч ирээд байгаа юм. Нийгмийн үнэ цэнэ гэдэг зүйл дээр бид том алдаа гаргаад байна.

Монгол Улс мега төслүүдээ саалийн үнэтэй зүйрлэдэг. Тэгвэл өдгөө саалийн үнээнүүдийн маань нэг Оюутолгой саалиа өгөөд эхэлсэн. Цаашлаад бүрэн хүчин чадлаараа ажиллах бололцоогоо хүлээж суугаа. Үүнтэй зэрэгцэн Тавантолгой мега төслийн ажил ундарч маргаан нь зэрэгцэж байна. Тэгвэл энэхүү хэлэлцээрийн тал дээр зочид ингэж хэлж байна.

-Д.Жаргалсайхан

Зорилго тодорхой байхад түүнд нийцүүлж бүх юмыг хийх ёстой. Зорилго байхгүй болохоор Дорж нэг талаас харахаар болохгүй, Дондог гуай нөгөө талаас нь харахаар бас болохгүй үзэгдээд байгаа. Үүнийн адилаар Тавантолгойг хүн бүр өөрийнхөө нүдээр хараад зарим нь энэ дундаас мөнгө олох гээд, зарим нь итгэл үнэмшлээрээ ирээдүйдээ үлдээе гэж ярьж байгаа хүмүүс ч байна. Аль алиныг нь буруутгах арга байхгүй. Зорилготой бол түүндээ захируулах хэрэгтэй байгаа юм. Ер нь эдийн засгийн эрх чөлөө нь хангагдчихсан дугаар хорооны иргэний хийж байгаа зүйлээс нийгэм нь яаж үр шим хүртэж байгаа юм бэ гэдэг загвар нь



Д.Жаргалсайхан

“ Байгалийн баялгаа дарж үлдвэл бид мөнгөгүй болж хөгжихгүй, хүчирхэгжихгүй ”

бусад оронд бий. Үүнийг нь бид багахан юм хийгээд мөнгөтэй болчихоор нь олигархи, шуналтан, хөрөнгөтөн гээд янз янзаар хэлнэ. Энэ биш ээ. Хайрганы уурхайгаар жишээ авч үзвэл, тэнд хүн ажиллана. Хайргаа зөөж, тээвэрлэхийн тулд шатахуун, тоног төхөөрөмж, банкны үйлчилгээ авна. Эдийн засгийн бусад салбараа дэмжиж байгаа юм. Дараа нь татвар төлнө. Гэтэл нөгөө гол татвар төлөгчдөө хүлчхээр татвар болон эдийн засгийн бусад салбарын үйлчилгээ, ажилладаг хүн байхгүй, улмаар хөрөнгө оруулсан хүн нь хохироод үлдэнэ. Энэ загвар монголчуудын тархинд буухгүй байгааг харуулж байна.

-Б.Эрдэнэбат

Оюутолгой ил, далд уурхай гэсэн хоёр хэсгээс бүрдэж байгаа. Ил уурхайгаас гарч байгаа бүтээгдэхүүний хэмжээ Эрдэнэтийн уурхайгаас аль хэдийнэ давчихсан. Тэгэхээр бид 2000-аад онтой харьцуулахад хоёр Эрдэнэттэй сууж байна. Яагаад байдал өөрчлөгдөхгүй байгааг, тэр мөнгийг бид зөв зарцуулж чадаж байгаа эсэхийг асуух ёстой. Гэтэл энэ хоёр уурхайн төслийг хэрэгжүүлсний дараа бүх зүйл сайжирчихсан байна гэдгийг хэн хэлж байгаа юм. Мэдээж явцдаа бол байдал сайжирна. Эдгээр

төсөл хөгжлийн мотор болохгүй. Харин цахиур болж чадна.

-Ө.Ганзориг

Товчхондоо, Тавантолгойг явуулах ёстой. Юуны өмнө бид ямар нөхцөл байдалд байгаагаа мэдэх ёстой. Нэгдүгээрт, бид эдийн засаг, нийгмийн хүчин чадавхын хувьд дэлхийгээс хоцорчихжээ. Бид өнөөдөр нэг уул алдахгүй гээд хоорондоо булаацалдаад байна. Ингэсээр бид газар нутгаа бүхэлд нь алдана. Нэг л өдөр Монгол Улс гэдэг нэр ойлголт байх уу, үгүй юу гэдэг асуудал яригдана шүү. Жишээлбэл, 40 орчим сая хүн амтай том улс Украин өнөөдөр яаж тоглуулж байна. Украйнаар тоглож байгаа улс манай хойд хөрш. Өнөөдөр бид уул уурхайг уул, ус ярьж зогсоож байна. Ингэснээр бид мөнгөгүй болж байгаа юм. Зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт, мөнгөний эх үүсвэргүй болж байна. Гэтэл байгалийн баялгаа дарж үлдээд, мөнгө байхгүй болохоор бид хөгжихгүй, хүчирхэгжихгүй. Тэгээд хэдэн жилийн дараа бид бүх газар нутгаа алдах эрсдэлд хүрнэ. Энэ бол одоо байгаа нөхцөл байдал.

Аливаа юманд философийн болон эдийн засгийн гэсэн хоёр хүчин зүйл байдаг. Философийн хүчин зүйл болох итгэл үнэмшил байж ажил хэрэг урагшилдаг. Гэтэл Монголын ард түмэнд өнөөдөр итгэл үнэмшил байна уу. Философийн хүчин зүйлийн хувьд дэлхийтэй харьцуулахад бид хаана байна вэ? Бид өнөөдөр бие биенийгээ аль нэг улсын эрлийзээр нь дуудаж байна. Философийн боловсролоороо дэлхийн улсуудаас хойно байна. Ард түмэнд итгэл үнэмшил, урам зориг, сэтгэл зүйн хүч, хат тэнхээ гэж зүйл алга. Эдийн засгийн аливаа шийдвэр гаргалтад цаг хугацаа хамгийн чухал. Зөв цагт зөв үнээр нь зарах, авах асуудал байдаг.

Тавантолгойг бид 2011 онд зарах ёстой байсан. Австралид ойрын 15 жилд дахин үер болохгүй. Тухайн үед, нүүрсний үнэ байж болох хамгийн дээд түвшинд хүрсэн үед нь бид Тавантолгойн орд газрыг олон улсын зах зээлд зарах ёстой байсан. Зарна гэдэг нь зуун хувь байх албагүй. Харин одоо бид хувьсах байдлаар шийдэж болно. Одоогийн тохиролцоогоор зарахгүй,

түрээслэх гээд байгаа юм билээ. Тэгэхээр энэ цаг хугацааны асуудалд манай төрийн тэргүүнүүд мэдрэмжгүй хандаад байна. Бизнес эрхлэгчид боловсролын системийг сайжруулбал бүтээмж өндөртэй ажилтан бэлтгээд, илүү их мөнгөн орлого бий болгож өгөх юм байна гээд үүнийг ойлгох хэрэгтэй. Төрөөс боловсролд анхаарах ёстой. Төрд бизнесийнхэн орж ажиллавал боловсролын салбарт анхаарна.

Дэлхийн нийтээр хөгжлийн дараагийн хувьслыг хүлээж байна. Энэ нь техник технологийн дэвшил, шинэ нээлт. Гэтэл бид хөгжлийн өнгөрсөн үеийг туулж байна. Монгол Улс эдийн засгаа аврах нэг гарц нь гадаадын хөрөнгө оруулалт гэж хаа хаанаа ярьж буй. Д.Жаргалсайхан захиралын хэлж буйгаар биднийг гаднынхан шохоорхож байна. Энэ шохоорхол сонирхол болж, сонирхол нь итгэл үнэмшил болдог учиртай. Тэгвэл хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээхийн тулд бид юу хийх хэрэгтэй вэ?

-Д.Жаргалсайхан

Гадныхны хамгийн их айж байгаа зүйл нь манайхан гэнэт хууль гаргадаг асуудал. Үүн дээр “Шоронд хийчих вий” гэх айдас нэмэгдчихлээ. Магадгүй монголчууд суралцах шатандаа явж байгаа байх. Монгол гэх гурван сая хүн амтай “тээврийн хэрэгслийг” авч явахад нэлээн хэдэн хэмжүүр хэрэгтэй юм шиг байгаа юм. Тэр хэмжүүрээр бид зорилгодоо хүрч байна уу, үгүй юу гэдгийг хэмжмээр байна. Энэ хэмжүүрийг бид гаргах хэрэгтэй. Монголын бодлогын бичиг баримтуудаас бидэнд зорилго гэж зүйл байна уу гэж хайж үзлээ. Үндсэн хуулийн эхэнд “...Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж. Гэтэл үүнд хэмжүүр нь байхгүй болохоор зорилго гэхэд учир дутагдалтай.

Хүний биеийн халуун, даралтыг нь үзэж, олон төрлийн шинжилгээ хийж оношилдог шиг бид улсаа оношлох хэрэгтэй байна. Оношлох гэхээр иж бүрэн, цуглуулсан баримт, мэдээлэл алга. Үүнийг бид нэн даруй бий болгох хэрэгтэй. Түүнээсээ харж байгаад хаана өвдчихсөн байгаага оношилж, эмчлэх хэрэгтэй байна. 2014 онд “Фризер”-ийн

институтээс гаргасан Эдийн засгийн эрх чөлөөний индексийн судалгаанаас харахад дэлхийн 152 орноос Монгол Улс доороосоо хоёр дахь ангилал буюу багахан эрх чөлөөтэй гэдэгт жагсаж байна. Мөн “Херитеж Фаундэйшн”-ийн судалгаагаар бүр эдийн засгийн эрх чөлөө байхгүй гэж байна. Төрөөс бодлогоо боловсруулахдаа наад зах

“ Хөрөнгө оруулагчдад тодорхойгүй байдлаас гадна шоронд хийчих вий гэх айдас НЭМЭГДЧИХЛЭЭ

нь өөрсдөө гаргадаг Эдийн засгийн өрсөлдөх чадварын судалгааг ашиглах хэрэгтэй байна. Ингэвэл бид байнгын дохио өгч байдаг хянах самбартай байх боломжтой. Бид зөвхөн гаднын хөрөнгө оруулагчид гэж ярихаа больё, дотоод руугаа харъя. Хөрөнгө гэж зөвхөн мөнгө биш. Хувь хүнд байгаа бүх нөөц боломж. Монголын иргэн бүрт өөрийн гэсэн хөрөнгө, боломж бий. Түүнийгээ өөрт бас өрөөлд ашигтайгаар гаргах боломжийг нь нээж өгөх хэрэгтэй байна.

-Ө.Ганзориг

Манайхан 1990 онд чөлөөт зах зээл улс орныг хөгжүүлдэг юм байна гэж ойлгосон гэх дүгнэлт байдаг. Боловсролын систем гэдэг ой, ширэнгэд үйлчилдэг шиг бичигдээгүй хуулиар өрсөлдөөн нь явдаг юм байна. Хэн мундаг нь товойж гарч ирдэг. Өөр улстай өрсөлдөнө гэдгийг тооцооноос хассан. Ингээд төрийн философийн тогтолцооны маш том алдаа гаргаад 24 жил явчихлаа. Бидэнд өнөөдөр шилэн байшин байна. Гэтэл биотехнологийн парк алга. Хувийн эмнэлгүүд байна. Гэтэл олон улсын жуулчдыг татдаг эмчилгээний парк алга. Тэгэхээр бидэнд өнөөдөр юу ч алга. Төрийн үүрэг бол дэмжих, чиглүүлэх. Компаниар бол гүйцэтгэх захирлын үүрэгтэй ижил. Гүйцэтгэх захирал ажил хийгээд явдаггүй, ажилтнуудаа юу хийхийг нь чиглүүлж өгөөд, төсвийг нь баталж, дэмжиж өгдөг.

Олон улсад эдийн засагт бүтцийн



Ө.Ганзориг

өөрчлөлт хийх тухай асуудал ярьж байна. Манайд өнөөдөр энэ талаар ярьж байгаа юм алга. Төсвөө жаахан таначихъя, халамжийн бодлогоо эргээд харъя л гэж байна.

Уг нь бол энэ нь өдөр тутамд хийж байх ёстой зүйл. Компанийн захирал байнга л төсвөө харж, илүү зардлыг нь хянаад явдаг ш дээ. Тэгэхээр одоогийн юм уу, дараагийн Ерөнхий сайдаас ард түмэн нэг л зүйлийг хүсэх ёстой. Энэ нь Монгол Улс 50, 100, 500 жилийн дараа хаана байх зорилго тавьж, тэр зорилгодоо хүрэх бодлого нь юу юм, энэ бодлогын хүрээнд төр юу хийх юм, хувийн хэвшил яах юм бэ гэдэг нэгдсэн байдал, явах чиг.

Эдийн засагч, бизнес эрхлэгчдийн төлөөллүүдийн хэлж буйгаар Монгол Улсад бүтцийн өөрчлөлт заавал хийх хэрэгтэй байна. Ингэхийн тулд бүрэлдэхүүн хэсгүүдийг нь судлаж, шинэчлэх нь чухал юм. Хэрвээ үүнийг хийж чадвал ирээдүйд -тос масло нь таарсан машиныг хараад хэдэн километр ч явахаар итгэл үнэмшил хүнд төрдөг шиг- хэдэн жилдээ нийгэм тэр чигээр замнах боломжтойг Д.Жаргалсайхан учирлалаа.

Бизнес эрхлэгчид Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн санал асуулгын хариуг дөнгөлүүлсэн хүмүүсийг суллах, ажлыг нь хийлгэх гэсэн санаа гэж харж байгаа аж. Нөгөөтэйгүүр гаднын хөрөнгө оруулагчдаа татах зам гэж харж байгаа хэсэг ч бий. Монгол Улсыг бүтэн оношлогоонд оруулах шаардлагатай байгааг тэд учирлалаа. ■

Стэнд бай хөтөлбөрийг биш, мега төслүүдийг сонголоо

Э. Эрдэнэтунгалаг

Одоогийн долларын чангарал, төсвийн алдагдлын хэмжээ бидэнд ОУВС-гийн Стэнд бай хөтөлбөр орж ирж байсан 2009 оны санхүүгийн хямралыг санагдуулж байгаа боловч хямралд хүргэсэн шалтгаанууд нь зарим талаараа төстэй, зарим талаараа ялгаатай. 2009 оны хямралын гол шалтгаан нь гэнэтийн ашгийн 68 хувийн татвар болон зэсийн үнийн бууралт байсан. Эдийн засгийн өсөлтийн гол тулгуур болж байсан зэс, алтны үйлдвэрлэгчдэд дээрх татварыг ногдуулсан нь Монголын эдийн засгийг гадаад зах зээлийн үнээс улам мэдрэмтгий болгосон бөгөөд зэсийн үнийн 70 хувийн уналт нь бидэнд шууд л хямралыг авчирсан.

Тус хямралаас гарахын тулд ОУВС-гаас авсан 18 сарын хугацаанд 229,2 сая ам.долларын зээлийг Монголбанкны гадаад валютын нөөцөд байршуулан мөнгөний болон төсвийн хатуу бодлогыг хэрэгжүүлсэн. ОУВС-гийн Стэнд бай хөтөлбөр бүсээ чангалах программ гэж ойлгож болох юм. Тус программ хэрэгжиж байх хугацаанд зээлийн жилийн дундаж хүү 22,2 хувьд хүрч, чанаргүй зээлийн нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь 17,4 хувьд хүрсэн нь хувийн хэвشلүүд болон банкны секторт сөргөөр нөлөөлж байсан боловч энэхүү төгрөгийн хумилт нь долларын чангарал, инфляцийг бууруулах зорилготой байлаа. Хэдий тийм боловч, тус хөтөлбөрийн хажуугаар

хямралын гол шалтгаан болж байсан зэсийн үнэ сэргэж, мөн зэс, алтад дарамт үзүүлж байсан гэнэтийн ашгийн 68 хувийн татварыг хүчингүй болгох шийдвэр гарсан нь тус программыг амжилттай хэрэгжихэд ихээр нөлөөлсөн. Мөн 2009 оны аравдугаар сард буюу тус хөтөлбөрийг дуусмагц Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ зурагдаж 6,2 тэрбум ам. долларын хөрөнгө оруулалт орж ирж эхэлсэн ба үүнийг даган хөрөнгө оруулагчдын Монголд итгэх итгэл нэмэгдэн ГШХО 2009-2011 оны хооронд найм дахин нэмэгдэж (570 сая ам.доллараас 4620 сая доллар болж) байсан түүхтэй. Мөн 2010 оноос нүүрсний салбар сэргэж эхэлсэн нь

2009 оны санхүүгийн хямралын шинжилгээ

Шалтгаан

Илрэл

Хямралаас гарахад



Эх сурвалж: YCX, Шинжээчийн дүгнэлт

Одоогийн хямралын шинжилгээ



*Улсын их хуралдааны үеэр, Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгч Б.Жавхлан нийт 5,8 тэрбум долларын экспортын 55% нь л Монголд бэлэн мөнгө байдлаар орж ирсэн гэж хэлжээ.

Эх сурвалж: УЦХ, Шинжээчийн дүгнэлт

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2011 онд 17,5 хувьд хүргэж дэлхий дээрх хамгийн хурдан өсөлттэй орнуудын нэг болгосон.

2009 оныхоос ялгаатай нь одоогийн Монголд үүсээд байгаа эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй байдал нь зөвхөн гадаад хүчин зүйл буюу гол эрдэс баялгийн үнийн бууралтаас (Монголын хил дээрх нүүрсний үнэ 2011 оны есдүгээр сард 181\$/т хүрч байсан нь 35 \$/т –д хүрээд байна) гадна бодлого боловсруулагчдын шийдвэр болон гадаадын эзэмшлийн хувиас гэнэтийн ашгийн 68 хувийн татвар болон зэсгийн үнийн бууралт байсан.

- **Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин:** 2010 оны дунд үеэс эхэлсэн нүүрсний үнэд суурилсан өсөлтийн үед Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийг шинээр бий болгосон ба Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай (СААНХО) хуулийг шинээр баталсан. Мөн Эрдэс баялгийн тухай хуульд өөрчлөлт оруулах талаар яригдаж байсан нь хөрөнгө оруулагчдын Монголоос зугтах шалтгаан болсон. 2012 оны дунд үеэс эхлэн нүүрсний үнийн уналт эдийн засгийг дордуулснаар бодлого боловсруулагчид СААНХО

хуулийг цуцалж хөрөнгө оруулагчдад илүү тааламжтай шинэ хөрөнгө оруулалтын хууль болон эрдэс баялгийн бодлогоо баталсан ч хөрөнгө оруулалт сэргэхгүй хэвээр л байна. Энэ нь долларын чангарал болон төсвийн алдагдлын нэг шалтгаан болоод байгаа.


- **Экспортын Монголд наалдац багатай өсөлт:** Монгол Улсын уул уурхайн ихэнх төсөл гаднын хөрөнгө оруулалттай байдгийг бид мэднэ (нийт ГШХО-ын 70 орчим хувь нь уул уурхай руу ордог). Учир нь Монголд бакны зээл олгох чадамж хязгаарлагдмал, хөрөнгийн бирж хөгжөөгүй. Тиймээс гаднын хөрөнгө оруулагчид гаднаас мөнгө босгон бүтээн байгуулалтаа хийн үйл ажилгаагаа эхлэнгүүтээ олсон орлогоороо зээлээ төлөх шаардлага гарна. Тэр нь мэдээж гаднын зээлдэгчдэд очиж байгаа учир Монголд орж ирэхгүй. Харин шаардагдах нэмэлт хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардал (татвар, цалин, бараа үйлчилгээний худалдан авалт) болон Засгийн газрын хувь эзэмшлийн ногдол ашиг нь долларын урсгал болон Монголд орж ирнэ. Тиймээс Их хурлын чуулганы үеэр, Монголбанкны

Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Жавхлан 2014 оны нийт 5,8 тэрбум ам. долларын экспортын 55 хувь нь л Монголд бэлэн мөнгө хэлбэрээр орж ирсэн тухай мэдэгджээ. Тиймээс гадаад худалдааны тэнцэл эерэг харагдаж байгаа ч үнэн хэрэгтээ бэлэн мөнгөний хувьд алдагдалтай байгаа бөгөөд энэ нь доллар чангарах шалтгаануудын нэг нь юм.

- **Их хэмжээний төгрөгийн нийлүүлэлт:** Төгрөгийн нийлүүлэлт нэмэгдэхээр мэдээж хэрэг төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрана. Засгийн газрын бэлэн мөнгө тараах бодлого, найман хувийн орон сууцны зээлийг болон үнэ тогтворжуулах хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор хэвлэсэн Монголбанкны төгрөгийн нийлүүлэлт бүгд үүнд хамаарна.

Энэ удаагийн эдийн засгийн хүндрэл 2009 оныхоос улам дор гэж хэлж болно. Учир нь Монгол Улс их хэмжээний өрийн дарамтад байгаа бөгөөд гол эрдэс бүтээгдэхүүний үнийн өсөлт богино хугацаанд ажиглагдахгүй байсаар байна. Үүнээс гадна, төсвийн гадуурх зардлыг оруулан тооцвол Засгийн газар зардлаа орлогын түвшнээсээ хамаагүй их байлгасан (төсвийн алдагдал ДНБ-ий 10 хувьд хүрэхээр) нь төгрөгийн нийлүүлэлт

ихээр хийснийг харуулж байна. Мөн Монголбанкны гадаад валютын нөөцийн түвшин цэвэр дүнгээрээ хасах руу ороод буй. Тиймээс бид зах зээл дээрх төгрөгийн нийлүүлэлтийг 2009 оныхоос багасгах хэрэгтэй. Үүний тулд сангийн бодлогоо хумиж (төсвийн зардлыг танах), мөнгөний бодлогоо хатуу болгох (зээлийг багасгах) зорилгоор ОУВС болон Дэлхийн банкны санал болгоод буй 600 сая ам.долларын хөтөлбөрүүдийг авах шаардлагатай. ОУВС илүү төлбөрийн тэнцлийн алдагдал руу анхаарлаа хандуулдаг бол Дэлхийн банк илүү төсөвт төвлөрдөг. Хэдийгээр энэхүү арга хэмжээ нь богино хугацаандаа дотоодын хувийн секторт зээлийн хүү болон хэрэглэгчдийн



“
Тавантолгойн
1072 ширхэг
хувьцаа
бас л нэг
бэлэн мөнгө
тараалт
”

эрэлтийг бууруулах замаар сөргөөр нөлөөлөх боловч ингэснээр импорт бууж ам.доллар сулран инфляци буурах боломж бүрдэнэ. Энэ нь эргээд хувийн секторуудын зардлыг бууруулан эерэгээр нөлөөлж эхэлнэ.

Гэвч 2017 оноос эхлэн бид өрөө төлөх ёстой учраас ОУВС бидэнд ганцаараа тусалж чадахгүй нь мэдээж. Тиймээс ОУВС-гийн Стэнд бай хөтөлбөрийн хажуугаар 2009 оныхтой адилаар ядаж аль нэг мега төсөл нь хэрэгжих шаардлагатай байна. Одоогийн байдлаар Тавантолгойн асуудал амжилттай явагдаж байгаа бөгөөд нийт шаардлагатай 3.0 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын нь 1.0 тэрбум нь

2015 онд ТТ-Гашуунсухайтын төмөр замыг санхүүжүүлэх магадлалтай байна.

Одоогийн эдийн засаг, санхүүгийн хүндрэлээс гарахын тулд эрх баригчид ОУВС-гийн Стэнд бай хөтөлбөрийг буюу бүсээ чангалах бодлогыг явуулахгүйгээр томоохон төслүүдээ явуулахаар шийдсэн нь хоёрдугаар сарын 18-ны намрын чуулганы шийдвэрүүдээс илхэн харагдлаа. Урт нэртэй хууль болон Ашигт малтмалынхаа хуульд дахин нэмэлт, өөрчлөлт оруулан хөрөнгө оруулалтыг уул уурхай руу татахаас гадна Өрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан төрийн өмчит байгууллагуудын зээл болон Засгийн газрын баталгааг улсын өрөөс хасахаар болсон байна. Энэ нь Засгийн газарт нэмэлт өр тавих боломжийг олгоно. ОУВС хатуу шалгууруудыг Засгийн газар болон Монголбанкинд тавьж орж ирдэг учир зарцуулах эрх мэдлээ багасгахгүйн тулд ОУВС-гийн Стэнд бай хөтөлбөрийг авахын оронд өөрсдийн эдийн засгийн хүндрэлийг даван туулах 70 заалттай

арга хэмжээгээ баталсан байна.

Нэгэнтээ хуулиуд нь батлагдаад шийдвэр нь гарчихсан учир бидний өнгөрснөөсөө сурах зүйл бол дахин урьдчилгаа төлбөр авч бэлэн мөнгө хэлбэрээр тараахгүй байх явдал юм. Ер нь бол иргэдэд тараасан Тавантолгойн мөнгө нь олгогдоогүй байгаа 1072 ширхэг хувьцаа бас л нэг бэлэн мөнгө тараалт болж хувирна. Тараасан мөнгийг иргэд аваад үрнэ, энэ нь 70 хувь импортоос хамааралтай хувийн секторуудын эрэлтийг нэмж, доллар чангарна бас үнэ өснө. Тэнгэрт хадсан үнийн өсөлт ужигрна уу л гэхээс буцаад буудаггүй. Тиймээс иргэдийн халаасанд ороод гарах мөнгө байнга худалдаж авдаг зүйлийнх нь үнийг өсгөөд байнгын орлогод нь нөлөөлөхгүй. Харин үүнийхээ оронд шавхагдах баялгаасаа олсон орлогоороо дэд бүтэцдээ хөрөнгө оруулалт хийн, хүчин чадал нь хүрэлцэхгүй байгаа цэцэрлэг, эмнэлэг, сургуулиа барьж болно. Хамгийн чухал нь иргэдийнхээ боловсролыг дэмжих хэрэгтэй. ■

Хууль

Морин жилийн сүүлэн дээр

Ц.Элбэгсайхан

Улсын Их хурлын намрын чуулган товлосон хугацаанаасаа долоо хоногийн дараа, хоёр дугаар сарын 18-ны өдөр өндөрлөсөн. Учир нь УИХ-ын дарга З.Энхболд Засгийн газраас өргөн мэдүүлсэн яаралтай горимоор шийдэх ёстой хуулийн төслүүдийг хэлэлцэх шаардлагатай учир захирамж гаргаж чуулганы хугацааг сунгасан юм. Ингээд билгийн тооллоор морь жилийн өвлийн адаг сарын 30-н буюу битүүний өдөр намрын чуулганы сүүлийн хуралдаан болж дуусав.

Энэ өдрийн хуралдаанаар олон нийтийн дунд хэрхэн шийдэгдэх бол хэмээн хүлээлт үүсээд байсан Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах, Урт нэртэй хуулийн дагаж мөрдөх журамд өөрчлөлт оруулах, Өрийн удирдлагын тухай хуулийн төслүүд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтыг огцруулах тухай, Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай тогтоолын төслүүдийг хэлэлцжээ.

Битүүний өдрийн чуулганы хуралдаанаар ийнхүү олон асуудлыг хэлэлцэж, шуурхай шийдвэрлэжээ. Гэхдээ олон нийтийн хэрхэн шийдэх бол хэмээн хүлээж, чих тавьж байсан бараг бүх асуудлыг нэг өдөрт, бүр яривал хэдэн цагийн дотор “бөөндөж” шийдсэн нь эргээд шүүмжлэл дагуулах шалтгаан болоод байна.

Чуулганы хуралдаанаар хэлэлцсэн эхний асуудал “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг байжээ. Хэлэлцүүлгийн үеэр асуулт асууж, санал хэлэх гишүүн гараагүй байна. Ингээд санал хураалт болоход гишүүдийн олонх дэмжиж, тогтоолыг баталсан байна. Тогтоолын төслийн гол агуулга нь эдийн засгийн хөгжлийн удаашралын эсрэг төлбөрийн тэнцлийн хямралыг эрүүлжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг авах юм. Үүнд багтаж байгаа нэг чухал алхам нь гадаадын зээлийг нэмэгдүүлэх боломжийг нээх

замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. Мөн мега төслүүдээ эрчимжүүлэх тухай шийдвэрүүд багтаж байгаа юм.

Үүний дараагаар Урт нэрт хуультай холбогдох асуудлуудыг хэлэлцжээ. Мөн л гишүүдэд асуулт байгаагүй, олонхын саналаар баталсан байна. Журамд өөрчлөлт оруулахаас өмнө хуулийн үйлчлэлд хамрагдсан талбайд нийт 909 хайгуулын тусгай зөвшөөрөл, 427 ашиглалтын тусгай зөвшөөрөл тоологдсон байдаг. Шинэ батлагдсан журмаар хязгаарлалтын бүсийг илүү тодорхой болгож өгсөн бөгөөд хязгаарлалтын бүсэд 200 метрээс дотор олборлолт хийхийг хориглож байгаа юм. Үр дүнд нь 300 гаруй газар уул уурхайн олборлолт сэргэх боломжтой болно гэж үзэж байгаа аж.

Гурав дахь чухал асуудал Өрийн удирдлагын тухай хууль. Хуулийн төслийг анх 2014 оны дөрөвдүгээр сарын 30-нд өргөн барьсан боловч өөрчлөлт оруулахаар энэ оны хоёрдугаар сарын 2-ны өдөр эгүүлэн татсан байдаг. Ингээд өөрчлөлт оруулж, найруулсан хуулийн төслийг хоёрдугаар сарын 6-ны өдөр УИХ-аар нэн яаралтай хэлэлцүүлэхээр дахин өргөн барьсан юм. Энэ хуулийг батлахын тулд төсөвтэй холбоотой хуулиудад өөрчлөлт оруулж байгаа. Тухайлбал, Өрийн удирдлагын тухай хуульд Улсын төсөвт эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр өр үүсгэх зориулалтыг тусгайлан зааж тусгасан, “өрийн тааз” буюу Монгол Улсын гадаадаас авах зээлийн хэмжээг 40 хувиас хэтрүүлэх ёсгүйгээр зохицуулж байсныг ДНБ-ий 60 хувьд хүргэж нэмэгдүүлээд байгаа.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх үеэр зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгээр нь батлуулахаар тус байнгын хорооноос горимын санал дэвшүүлжээ. Ингээд санал хураалтад оролцсон гишүүдийн 93 хувь нь дэмжсэнээр хуулийг эцэслэн баталжээ. Хуульд орсон гол өөрчлөлт нь стратегийн ордын төрийн эзэмшлийг

ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр авдаг болох зохицуулалт нэмэгдэж байгаа юм. Уг хуулийн төслийг хэлэлцэхээс өмнө “Сентера гоулд” компанийн эзэмшиж байгаа Гацууртын ордыг стратегийн ач холбогдолтой ордод бүртгэх, 20 хувийг төр эзэмших, мөн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлж болох тухай асуудал УИХ-ын чуулган дээр хэлэлцэгдэж, дэмжлэг аваагүй билээ.

Чуулганаар хамгийн сүүлд Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтыг огцруулах эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 97.6 хувь нь огцруулах шаардлагагүй гэж үзсэн байна. Асуудлыг хэлэлцэх үеэр огцруулах санал тавьсан гишүүд нэгдсэн хуралдаанд оролцоогүй учир хуулийн дагуу байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, санал хураалт явуулан асуудлыг шийдвэрлэхээр болжээ. Ингээд төрийн байгуулалтын байнгын хороо асуудлыг хэлэлцээд Засгийн газрын гишүүнийг огцруулах шаардлагагүй гэж үзсэнээ танилцуулсан байна. Ийнхүү байнгын хорооны дүгнэлтийг олонх дэмжсэн хэрэг.

Дээрх гол хуулиудаас гадна тэдгээртэй холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэж баталсан. Мөн Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга нарыг томилсон юм. Эдгээр албан тушаалтныг УИХ-ын даргын санал болгосноор томилдог бөгөөд УИХ-ын дарга З.Энхболд Сонгуулийн ерөнхий хорооны даргаар Ч.Содномцэрэнг улираан томилуулах, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргаар Ц.Болдсайханыг томилуулах саналаа танилцуулж, гишүүд дэмжсэн байна. ■



Зураач: Энхбатын Цолмонбат
"Салхины ингэмэлдэл"

Тал нутгийн салхи зөөлнөөр үлээхэд адуу ившээж салхитай уралдан давхилдахуй. Гоо бүсгүйчүүл толгойн чимэглэлээ гайхуулан ихэмсэгээр үл мэдэг инээмсэглэн сүү мэт сэтгэлийн чанад эх хүний үрээ, эх орноо гэсэн бодрол тэдний харцанд илхэн. Энэ зурагт монгол эмэгтэйн дүр төрх, үндэсний уламжлалт хувцас хэрэглэл нь зөвхөн халх эмэгтэйгээр зогсохгүй Мянгад, Барга, Үзэмчин, Төв хүрээний донж төрхийг тодоор зурж дүрсэлжээ. Эмэгтэйчүүдийн толгойн чимэглэл нь монгол дарханы сэтгэлийн ур, гарын ур, нүдний ураа шингээн дархалсан нь дахин давтагдашгүй, үндэсний хэв шинжийг хадгалан утга санаа агуулсан түүхэн баримтыг шингээсэн учир энэхүү зурагт тод томруунаар нарийвчлан зурж дүрсэлжээ.



Тэгш оролцоо

Далд хуйвалдаан эдийн засгийг “дарлаж” байна

Б.Үүрийнтуяа

Өсөлт гээчийг хүсэл болгоод дэлхийн эдийн засаг нэлээд удаан явчихлаа. Харин хүсээд буй өсөлт, түүнд хүрэх арга зам нь тун энгийн болохыг Олон улсын валютын сангийн захирал Кристин Лагард ийн сийрүүлжээ.

Эмэгтэйчүүдийн эсрэг “далд хуйвалдаан” дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байгааг Кристин Лагард онцлов. Тэрбээр жишээ татан хэлэхдээ “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг хууль эрх зүйн хүрээнд буюу “далд хуйвалдаанаар” хааж байгаа нь дэлхийн зарим орон ДНБ-ийхээ 30 хүртэлх хувьтай дүйх өсөлтийг сайн дураараа булшилж буй хэрэг болж байна” гэв. Тодруулбал, Энэтхэг, Турк, Пакистан, Египт зэрэг улсад эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг болоод улс төрийн оролцоог түтгэлзүүлж байгаа нь дээрх дүгнэлтийг

гаргах энгийн жишээ аж. Олон улсын валютын сангаас гаргасан саяхны судалгаанд үндэслэн Кристин Лагард “Эмэгтэйчүүдийг дэлхийн хэмжээнд тоглолт хийх боломжоор хангаснаар найдаж болохуйц өөрчлөлт авчирна” хэмээв. Эр, эм гэж ялгах нь тухайн улсад орох хэдэн тэрбум ам.долларын боломжит урсгалыг боож байгаа хэрэг гэдгийг ч тэрбээр тайлбарласан байна.

Нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, нэмэгдүүлэх нь зөвхөн жендерийн эрх тэгшийн асуудал биш аж. Тэднийг амжилтын тавцанд гаргаж ирэх нь эрчүүдийн ноёрхолыг дарах гэсэн үг огтоос биш, харин тэдэнд хүч нэмэх түлхэц болох тухай тус сангийн захирал цохон тэмдэглэсэн байгаа юм. Лагардын үзэж буйгаар эмэгтэйчүүдийн оролцоо гэдгийн гүн утга эдийн засагт

дэмжлэг болоход орших ажээ. Үүний хамгийн энгийн илрэл нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт гэж. Олон улсын валютын сангийн захирал “Харамсалтай нь, гартаа буй таатай боломжийг эргэцүүлэн бодохоос татгалзаж, түүний боломжит үр дүнг нээн илрүүлэхэд анхаарлаа хандуулахгүй байна” хэмээн өөрийн блогтоо нийтэлсэн байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг хязгаарлаж буй нь өнөөдөр дэлхий нийтэд хамгийн их хэрэгтэй байгаа эдийн засгийн өсөлтийг хойш чангааж байгааг тус сангийн судлаачид мөн баримтжуулсан байна.

Дэлхийн банкнаас гаргасан статистик үзүүлэлтүүдэд суурилан Олон улсын валютын сангийн судлаач, шинжээчид эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн зах зээлээс ангид байлгах нь сөрөг нөлөө ихтэй болохыг судлан тооцоолжээ.

Олон улсын эмэгтэйчүүдийн өдөрт

Эмэгтэйчүүдийн сэтгэлгээний хувьсал

Ц.Элбэг

Эцгийн эрхэт ёс хүй нэгдлийн үеэс эхлэн хэдэн мянган жилийг дамнан өнөөг хүртэл оршин тогтжээ. Эцгийн эрхэт ёс гэдгийг зөвхөн өрх гэрийн тэргүүнийг хүндлэн дээдлэх үзэл хэмээн олон нийт буруу ойлгох нь бий. Энэ бол эмэгтэй хүний нийгэмд эзлэх байр суурь, үнэлэмж эрэгтэй хүнээс доогуур байдаг, байх ёстой гэсэн үзэл суртал юм. Аугаа их сэтгэгчид, философичид амьдарч, номлолоо айлдаж байсан эртний Грект хүртэл “Эмэгтэй хүн тахиатай тэнцэнэ. Харин ухаантай эмэгтэй хүн хоёр тахиатай дүйнэ” гэж үзэж, үнэмшиж байсан байх юм. Хамгийн ардчилсан гэгдэж байгаа Америкт ч Абрахам Линкольныг Ерөнхийлөгч болох хүртэл эмэгтэй хүн сонгууль өгөх тухай дурсаад ч хэрэггүй байсан гэдэг.

Эмэгтэйчүүдийн эрх гэдэг нь хүний эрхээс ангид тусдаа ойлголт биш. Харин эмэгтэйчүүд хүний эрхээ бүрэн эдлэх тухай асуудал юм. Биеэ хамгаалах чадвараар сул доройгоос болоод тэднийг байнга халамжлах ёстой гэсэн явцуу үзэл гарснаар эр хүнээс хараат, нийгмийн оролцогч болохоос хөдөлгөгч хүчин биш гэж хандаж байв. Эмэгтэйчүүд өгөгдсөн эрхээ эдэлж чадахгүй байгааг хүн төрөлхтөн хожуу боловч анзаарч эхэлж. Үүний дүнд 1980-аад оноос “эмэгтэйчүүдийн эрх” гэдэг ойлголтод өөрчлөлт оруулжээ. Ингэхдээ эрэгтэй, эмэгтэй хүн адил тэгш эрхтэй, ижил үнэлэмжтэй байх ёстой төдийгүй адил тэгш боломж эдлэх эрхтэй. Эмэгтэйчүүд эрчүүдийн адилаар шийдвэр гаргах түвшний үйл хэрэгт ч оролцох эрхтэй гэж үзсэн байна.

Орчин цагт эмэгтэйчүүдийн эрхийн асуудал илүү өргөн хүрээнд яригдаж, өөр шинэ асуудлууд тулгарч байна. Жендерийн хүрээнд хөндөгддөг даяар асуудлын нэг нь эмэгтэйчүүдийн эдийн засаг юм. Дэлхийн ядуу иргэдийн 70 хувь нь эмэгтэйчүүд байдаг гэж Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг хэлэхийг сонсоод гайхав. Дэлхийн нийт өмчийн нэг хувь л эмэгтэйчүүдэд ногдог бол

“ Эмэгтэй хүн тахиатай тэнцэнэ. Харин ухаантай эмэгтэй хүн хоёр тахиатай дүйнэ ”

үлдсэн 99 хувийг эрчүүд эзэмшиж байна. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдал муу нь бусдын эрхшээлд хялбар орох үндэс болдог аж.

Монголд ч эмэгтэйчүүдийн эдийн засаг чухал асуудал мөн. 2013 оны статистикийн судалгаагаар Монгол Улсад 81741 өрх толгойлсон эмэгтэй байна. Ажилчдын сарын дундаж цалинг хүйсээр, он тус бүрээр ангилж үзвэл эмэгтэйчүүдийн дундаж цалин эрчүүдийнхээс ямагт бага байсан нь тодорхой харагдах аж. Энэ судалгааны дүнг хамгийн сүүлд 2012 онд нэгтгэсэн байна. Тус оны байдлаар эрэгтэйчүүдийн дундаж цалин 593100 төгрөг байсан бол

эмэгтэйчүүд дунджаар 524300 төгрөгийн цалин авч байв. Харин улсын хэмжээнд дундаж цалин 557600 төгрөг байжээ. Мөн статистик тоо баримтаас харахад жил ирэх тусам эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж цалингийн зөрүү ихэсч байгаа нь ажиглагдах аж. Тухайлбал, 2003 онд дундаж цалингийн зөрүү 10 мянган төгрөг байжээ.

Хэдий тийм боловч зарим буурай оронтой харьцуулахад Монголд жендерийн тэгш байдал харьцангуй хангагдсан гэж хэлж болохоор. Охид, хөвгүүдийн сургуульд сурах эрх нээлттэй. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил эрхлэлтийн түвшин эн тэнцүүхэн. Хууль эрх зүйн хувьд олон улсын гэрээ конвенцид нэгдсэн, тэдгээрт зохицуулан хууль батлан хэрэгжүүлж байна. Түүнээс гадна өнөөдөр Монголын эмэгтэйчүүдийн холбоонд бүртгэлтэй 60 гаруй бие даан үйл ажиллагаа явуулдаг 40-өөд байгууллага, нийтдээ 100 орчим эмэгтэйчүүдээр “овоглосон” байгууллага бий. Жил бүр олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг улс даяар албан ёсоор тэмдэглэдэг гээд ололт олныг дурдаж болно.

Эмэгтэйчүүдийн боловсролын тухайд Үндэсний статистикийн хорооны судалгаанаас үзэхэд тэдний 97.7 хувь нь бичиг үсэгт тайлагджээ. 2013 онд бүх шатны сургууль төгсөгчдийн 54 хувь нь эмэгтэй. Тэднээс 30 орчим хувь нь дээд боловсрол эзэмшсэн. Цаашлаад их, дээд сургууль төгсөгчдийн 2/3 нь эмэгтэйчүүд байх жишээтэй. Гэсэн ч боловсрол, мэдлэг эзэмшсэн эмэгтэйчүүд шийдвэр



© Монголын Уран Зургийн Галерей | www.art-gallery.mn

гаргах түвшинд оролцож чадахгүй байсаар.

Улсын хэмжээнд цалинтай ажил эрхэлдэг иргэдийн 47 орчим хувь нь эмэгтэйчүүд боловч төрийн дээд байгууллага Улсын Их хуралд ердөө 11 эмэгтэй бий. Өмнөх парламентын үед гурвуулхнаа байсан эмэгтэй түшээд УИХ-ын сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчдийн 20 хувь нь эмэгтэйчүүд байна гэдэг квотыг хуульчлан тогтоосны үр дүнд арай олуулаа болоод байгаа нь энэ юм.

Дээр дурдсан ололт, амжилт бол бараг зуун жилийн хөдөлмөрийн үр дүн юм. Монголын эмэгтэйчүүдийн холбоо л гэхэд 90 жилийн түүхтэй. Социалист нийгмийн үед бүх хүнийг бичиг үсэгт сургахад анхаарч ажиллаж байсан.

Цаашлаад эмэгтэйчүүдийн боловсрол мэдлэгт анхаарч, боловсролтой эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд хүрч ажиллахад төрөөс нэлээд дэмждэг байжээ. Үүний дүнд 1980-аад оны үеэс Ардын Их хурлын депутатуудын 30 хувийг эмэгтэй гишүүд бүрдүүлж байсан тухай Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг ярьсан юм.

Харин 1990 оноос хойш энэ уламжлал алдагдаж төрд эмэгтэйчүүдийн дуу хоолой дутагдах болжээ. Эмэгтэйчүүд улс төрд “цөөнх” байгаа бас нэгэн шалтгааныг Ж.Эрдэнэчимэг тайлбарлахдаа “Юуны өмнө сэтгэлгээтэй холбоотой. Эрчүүд л төр түшдэг гэсэн уламжлалт сэтгэлгээ эмэгтэйчүүдэд ч байгаа учраас эрх мэдлийн хойноос хөөцөлддөггүй. Үүнээс

гадна эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн нь өөрөө хуйвалдаанд хутгалдсан, мөнгө хөрөнгөний асуудал болсон. Тэр бүү хэл, нэр төрийн төдийгүй амь насны асуудал болсон гэдгийг эмэгтэйчүүд мэдэж байгаа учраас улс төрд орохыг хүсдэггүй” гэсэн юм.

Монголын төрд эмэгтэйчүүдийн дуу хоолой хэрэгтэй төдийгүй чухал болохыг монголчууд хэзээнээсээ мэддэг учир түүний биелэлтийн төлөө ажилласаар иржээ. Өнөөдөр эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд оролцоогоо улам нэмэгдүүлэхэд тэдний боловсрол мэдлэг үл чамлагдана. Хууль эрх зүйн аливаа саад тотгор үгүй. Магадгүй эмэгтэйчүүдийн зориг, зүтгэл дутаж байж болох юм. ■

Тоон мэдээ

Монголын эмэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, цалингийн хэмжээ зэргийг тоон мэдээллийн хэсгээс сонирхоорой.

Сургууль төгсөгчид(мянга)

	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Ангилал											
Бүгд	102.9	118.2	128.1	131.1	132.8	134.5	134	139.5	133.7	167.8	150.6
Үүнээс: эмэгтэй	57.5	66.7	70.7	72	72.9	74.1	73.8	76.3	73.7	90.9	81.3
Ерөнхий боловсролын сургуулийг төгсөгчид	79.4	91.2	97.5	100.4	99.9	96.2	89.8	90.2	86.7	107	90
Үүнээс: эмэгтэй	42.9	49.6	52	53.2	52.6	50.7	47.5	46.9	45.5	55.2	47
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг төгсөгчид	5.2	5.9	8.2	7.1	7	8.7	11.2	15.1	11.2	23.1	23.4
Үүнээс: эмэгтэй	2.8	3.3	4.2	3.4	3.4	4	5.3	7.3	5.3	11.4	10.4
Их, дээд сургууль, коллежийг төгсөгчид	18.3	21.1	22.4	23.6	25.9	29.6	33	34.2	35.8	37.7	37.2
Үүнээс: эмэгтэй	11.8	13.8	14.5	15.4	16.9	19.4	21	22.1	22.9	24.3	23.9

Дундаж цалин(мянган төгрөг)

Он	Хүйс	2008	2009	2010	2011	2012
Улсын дүн	Нийт	274.2	300.4	341.5	424.2	557.6
	Эрэгтэй	291.2	322.6	370.4	470	593.1
	Эмэгтэй	258.1	279.9	314.5	381.3	524.3

Улсын их хурлын гишүүд

Үзүүлэлт	2000	2004	2008	2012
Бүгд	76	76	76	76
Эрэгтэй	67	71	73	65
Эмэгтэй	9	5	3	11

Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дунд эзлэх хувь /хөдөө аж ахуйгаас бусад салбар/(хувь)

Он	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Улсын дүн	51.1	53.1	53.1	53.9	53.1	53	47.4	47.5	46.5	47.8	47.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

*Улс төр, нийгэм, эдийн засаг дахь
эмэгтэйчүүдийн оролцоог ямар бодлого, арга замаар нэмэгдүүлэх
боломжтой вэ?*

Ж.Эрдэнэчимэг /Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч/



Төр, нийгмийг удирдахад жендерийн тэгш байдлыг хангах талаар бодлого байхгүй байна. Бодлого байлаа ч сонгуулийн тогтолцоо нь учир дутагдалтай. Улс төрийн эрх мэдлийг хариуцлага, улс орноо хөгжүүлэх гэхээсээ илүү хувь хүн, бүлэглэлийн ашиг хонжооны хэрэгсэл болгосон нь нийгмийн гажуудалтай холбоотой. Эмэгтэй хүн гэр бүлийн амьдралаа чухалчилдаг учраас ийм зүйл рүү орохыг хүсдэггүй.

Ц.Цэнд- Аюуш /“Ноосон зангилаа” дундын хоршооны дарга/



Улс төр эдийн засгийн амьдралд эмэгтэйчүүд оролцоо маш чухал. Гэтэл тэр болгонд бид үзэл бодолоо илэрхийлж, үр нөлөө үзүүлж чаддаггүй. Монголын нийгэмд эмэгтэйчүүд бидний нуруун дээр дааж давшгүй олон асуудал байна.

Жишээ нь, бүсгүйчүүд бизнес хийж байна. Үүн дээр айл гэрийн амьдралын ихэнх асуудлыг үүрч явдаг. Эмэгтэйчүүд УИХ-ын гишүүн болох гэж улайрдаггүй. Зөвхөн бидний дуу хоолой, тулгарч

буй асуудлуудыг цаг алдалгүй сонсож, дэвшүүлж байгаа санаануудыг дэмжиж, шийдэх ёстой асуудлуудад хариу өгөөсэй гэж хүсдэг. Үүнд л анхаараасай. Манай байгууллага хувийн хэвшилд хамрагддаг. Манай ажилчдын 90 орчим хувь нь эмэгтэйчүүд. Гэтэл хууль эрх зүйн хүрээнд хоршооны бизнесийн орчны дүрэмд шинэчилсэн найруулга хийх гэж найман жилийг үдлээ. Арай ч дээ л гэж хэлэхээс өөр үг олдохгүй байна. Монголын дайчин эмэгтэйчүүддээ хамгийн сайн сайханыг хүсэн ерөөе.

С. Даваасүрэн /МУИС-ийн багш/



Төрөөс хэрэгжүүлж буй аливаа бодлогыг нэг талаас үр ашиг, нөгөө талаас шударга байдалд үзүүлж буй нөлөөгөөр үнэлдэг. Энэ утгаараа шударга, тэгш байдал болон үр ашгийн хоорондын тэнцвэржилт хаана байгааг тогтоох нь төрийн бодлого, хөтөлбөрийн үндсэн шалгуур болдог. Эдийн засагт эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэхийн хэрээр бүтээмжийн өсөлт, баялагийн хуваарилалт сайжрах сайн нөлөөтэй. Харин шударга, тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлогын үйл ажиллагаа нь улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чухал хэрэгсэл гэж ойлгож байна.

С.Одонтуяа /Улсын Их хурлын гишүүн/

Эмэгтэйчүүд баялаг бүтээгчдийн эгнээнд орж эдийн засагт оролцоход шийдэх чухал асуудал бол ар гэрийн асуудал. Өнөөдөр эмэгтэй хүн үр хүүхдээ аюулгүй цэцэрлэг сургуульд явуулж байж тайван, амжилттай



ажиллаж хөдөлмөрлөх нөхцөл бүрдэнэ. Дараагийн асуудал бол эмэгтэйчүүдийн олж буй орлого нь эргээд маш их зардал болдог. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээ зэргээс эхлээд зардал ихтэй. Ийм болохоор улс төр, эдийн засаг дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд нийгмийн асуудлыг шийдэх нь зүйтэй.

Э.Цэцэгсайхан /Дэлхийн зөн олон улсын байгууллагын Хэнтий аймаг дахь хөтөлбөрийн багийн ахлагч/



Эмэгтэйчүүдийн оролцооны тухайд эмэгтэй хүн бүр улс төрч байх албагүй. Харин эмэгтэйчүүдийн төрд дуу хоолойгоо хүргэх нь нэг оролцоо юм. Энэ оролцоог сайжруулах арга, замыг нээлттэй болгож өгөх хэрэгтэй байна.

Төрийн шийдвэр гаргах түвшинд бүх эмэгтэйчүүд оролцож чадахгүй байгаа. Үүнийг нэмэгдүүлэхийн тулд орон нутгийн нэг сумын малчин эмэгтэй өөрийн саналаа хүргэх арга зам нь арга зам нь нээлттэй байх хэрэгтэй. Эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэснээр эдийн засаг дахь оролцоо нь сайжирна гэж ойлгодог. ■



Фотог Б.Бямба-Очир

Бизнесийн хүүхнүүд

Бизнесийн туршлага сууж, хүнд үеэ давсан ЭМЭГТЭЙ

Г.Орхон

Манай сэтгүүл “Бизнесийн хүүхнүүд” буландаа энэ удаа “Ханбогд Кашимер” ХХК-ийн ерөнхий захирал Ч.Ганцэцэгийг урилаа. Тэрбээр ноолуурын салбарт үйлдвэрлэлийн бизнес эрхэлдэг. 1998 онд компаниа үүсгэн байгуулж, 2005 оноос хойш жил дараалан “Топ-100” аж ахуйн нэгж, “Найдвартай татвар төлөгч” зэрэг хүндтэй шагналын эзэн болсоор иржээ. Дэлхийд алдартай брэнд үйлвэрлэгчид түүхий эдээ буюу боловсруулсан ноолуураа эднийхээс татаж авдаг. Мөн түүний хэдхэн хоногийн өмнө МҮХАҮТ-аас хоёр жилд нэг удаа шалгаруулдаг “Lady Entrepreneur-2014”-ийн Гран пригийн эзэн болсон баяраас нь бид хуваалцаж буйдаа баяртай байна. Ингээд бизнес эрхлэгч Ч.Ганцэцэг бүсгүйн ертөнцөөр аялацгаая.

Ноолуур угаах, самнах боловсруулах бизнест анх хэрхэн хөл тавьсан талаар ярилцлагаа эхлэх үү?

-Би өөрөө эдийн засагч мэргэжилтэй. Санаандгүй байдлаар энэ бизнесийг эхлүүлсэн. 1998 онд анх арав хүрэхгүй ажилтантай компаниа байгуулж байсан бол өдгөө 300 гаруй ажилтантай, Монголын шилдэг аж ахуйн нэгж болон ажиллаж байна. Манай компани байгуулагдсан цагаасаа хойш улсад 12 тэрбум төгрөгийн татвар төлжээ. Хэдий жижиг аж ахуйн нэгж ч гэсэн энэ ололт амжилтаа алдахгүйн төлөө ажиллаж байна даа.

Бараа, бүтээгдэхүүнээ дотоодын болон гадаадын зах зээл дээр борлуулдаг. Англи, Итали, Япон, Энэтхэг, Хятад гэх мэт олон улсад бүтээгдэхүүнээ нийлүүлдэг. Монгол ноолуураар дэлхийн

алдартай брэндүүдийг хийдэг учраас бид үйлдвэрлэлийн явц, чанартаа маш их анхаарч ажилладаг. Гаднын захиалагч компаниуд маань ч манайд өндөр хяналт, шаардлага тавьдаг. Бидний үйл ажиллагаа жилээс жилд өргөжиж байна. Энэ хэрээр самнасан ноолуур худалдан авах компаниудын тоо нэмэгдэж байгаа. Бид орон нутгаас ноолуур худалдан авч, ангилан ялгаж, угааж самнан экспортолдог. Европ руу агаараар “Korean air”, “Turkish airline” компаниар тээвэрлэж байна. Мөн Тянжинийн усан боомтоор далайн тээвэр хийн Хятад, Энэтхэг, Солонгост бүтээгдэхүүнээ борлуулж байна.

Дотоодын “Говь”, “Гоёо”, “Буян”, “Ээрмэл” зэрэг арав гаруй үйлдвэртэй хамтран ажиллаж, шаардлагатай үед самнасан ноолуураар хангадаг. Мөн

жигжиг, дунд үйлдвэрүүдтэй хамтран ажилладаг. Жилд нийт 90 тэрбум төгрөгийн борлуулалт хийдэг. Дэлхий нийтээрээ хямралтай байгаа учраас энэ онд борлуулалт 20 хувиар буурах төлөвтэй байна. Гадаад зах зээлийн үнэ буурч буйг даган дотоодод ноолуурын үнэ буурах хандлага байхыг үгүйсгэхгүй.

Ноолуураас өөр салбарт бизнесээ өргөжүүлж байгаа юу. Эдийн засгийн хүндрэлийн үед бизнесийн ямар стратегитэй ажиллаж байна вэ?

-Манай компани зөвхөн ноолуурын салбараас гадна санхүү, барилгын салбарт ажиллаж шинэ бизнест хөл тавьж, хүч сорьж үзэж байна. Хэдий хямралын үе ч гэсэн манай компанийн хувьд тэлэх бодлого барьж, ирэх дөрөвдүгээр сарын 1-нээс ажилчдынхаа цалинг тодорхой хувь хэмжээгээр нэмэх төлөвлөгөөтэй байна. Дэлхийн зах зээл дээрх таваарын ханш буурсан ч бид тогтвортой үйл ажиллагаа явуулж байх нь хамгийн том амжилт юм болов уу даа гэж бодож байна.

Дотоодын зах зээлд энэ салбарт өрсөлдөгч хэр олон бэ?

-Ноос, ноолуур угаах, самнах чиглэлийн 20 гаруй үйлдвэр байдаг. Өрсөлдөгч гэхээсээ гадна бид хамтарч ажилладаг болоод байгаа. Эдгээр үйлдвэр анх манай өрсөлдөгч байсан бол одоо бид нэг нэгэндээ бараа, бүтээгдэхүүнээ нийлүүлж, харилцан туршлага солилцож байна. Бид дэлхийн зах зээл дээр улсаа төлөөлөн хэрхэн өрсөлдөх, хамтарч ажиллах талаар сүүлийн хоёр жил нэлээд ярилцсан. Тэдний хийж чаддаггүйг би хийж чадаж байна. Миний чаддаггүй зүйлийг тэд хийж байна. Бид хамтарч дэлхийн зах зээлд өрсөлдөнө. Манай улс ноолуурын үйлдвэрлэлээрээ дэлхийд хоёрдугаарт ордог. Бид цаашид чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх ёстой.

Энэ салбарт бизнес эрхлэхийн онцлог нь юу вэ?

-Миний бизнесийн гараа энэ салбараас л эхэлсэн. Тийм учраас сурсан, дассан гэх үү дээ. Нөгөө талаас гадаад харилцаа өргөжсөн. Итали улсад импортолж байгаа самнасан ноолуурын 80 хувийг манай компани нийлүүлдэг болоод байна. Тус улсын

брэнд үйлдвэрлэгч ихэнх компани манайхыг мэддэг. Энэ бол бидний давуу тал. Тиймээс энэ бизнесээ цаашид үргэлжлүүлэхээс өөр аргагүй гэдгийг ойлгосон. Олон жилийн туршид олж авсан туршлага маань ч бий.

Дэлхийн брэнд үйлдвэрлэгчид Монголын ноолуур угааж, самнах үйлдвэртэй хамтран ажиллаж байна гэдэг сайхан санагдаж байна. Та бүхэн тэднээс юу сурч байна вэ?

-Дэлхийн томоохон брэнд хувцас үйлдвэрлэгч компанийнхан бидэнд их зүйл зааж өгдөг. Гаднынхан бидэнд чанарын хувьд өндөр шаардлага тавьдаг. Тэр олон шаардлагыг биелүүлж ажилладаг учраас манай компани энэ салбартаа тогтвортой ажиллаж байна. Эхэндээ гадаадын том компаниудын шаардлагыг хангаж ажиллахад манай ажилчдын хувьд хэцүү байсан. Дадаж сурсныхаа дараа үнэхээр зөв, хэрэгтэй гэдгийг нь ойлгож байна. Тухайлбал, Англи улсын томоохон брэнд үйлдвэрлэгч манай компанийн ажилтнуудад сургалт хийж байсан. Бид 100 ам.долларын цамц үйлдвэрлэж байгаа биш, манай түүхий эд эцсийн бүтээгдэхүүн болохдоо 2000 ам.долларын үнэтэй цамц болох жишээтэй. Бид Европын хатуу, чанга гэрээтэй нөхцөлд экспортоо хийдэг. Тэр болгонд тааруулан ажилладаг учир боловсорч байна.

Эмэгтэй хүн бизнес эрхлэх, тэр дундаа компани удирдаад явахын хэцүү нь юу вэ?

-Бизнес эрхлэхэд эрэгтэй, эмэгтэй хүнд адилхан асуудал, хүндрэл учирдаг. Бизнес эрхэлж байхад даваа, гүвээ их. Түүнийг давж гарах ёстой. Тэр бол нэг их хүнд асуудал биш. Бизнес хүн түүнийг даван туулах чадвартай байх нь чухал. Жижигхэн асуудал дээр нурмайж унаад байвал бизнес урагш явахгүй. Олон асуудал гарна. Би бол давах л ёстой гээд давдаг. Бизнес эрхлэгч улс төрд орж, улс төртэй холилдол буруу. Тэр хүн өөрийнхээ чаддаг юмаа л хийх ёстой. Бизнес хүн бизнесээ, улстөрч хүн улс төрөө хийх нь зөв.

Манай бизнесийнхэн яагаад дампуураад байна вэ гэвэл улс төртэй хутгалдсан учраас л тэр.

МОНГОЛ УЛСААС ЭКСПОРТОД БАРАА ГАРЧ БАЙГААД ХҮН БҮР БАЯРЛАХ ЁСТОЙ

Та бизнестээ ямар зарчим баримталдаг вэ?

-Шударга байх зарчим баримталдаг. Мөн хурдтай байхыг чухалчилдаг. Би ажилчиддаа ч хэлдэг. Хийх ёстой ажлаа цаг хугацаанд нь хийж, маш хурдтай байх ёстой гэж. Бид их хурдтай ажилладаг. Хувийн хэвшлийн хурдыг төрийн байгууллагынхан гүйцдэггүй. Төрийн байгууллагынхны удаанаас болж, тэр дундаа мэргэжлийн хяналтынхны буруугаас болж бид хохирол амсах нь энүүхэнд. Жишээлбэл, Цагаан сарын өмнө дөрвөн удаа бүтээгдэхүүнээ экспортолсон. Тэгэхэд Мэргэжлийн хяналтынхан хуралдсаар байгаад хяналтын бичиг гаргаж өгөөгүйгээс болж хоёр ч экспорт хийгдээгүй. Тэгээд амралтын өдөртэй нийлээд 10-аад хоногоор ажил саатчихаж байгаа юм. Гэтэл бүтээгдэхүүнээ борлуулахаар тохирсон гаднын компанийнхантай байгуулсан хатуу гэрээний хугацаагаа мөрдөөгүйгээс компани их хэмжээний торгууль төлөх жишээтэй. Энэ зөвхөн манай компани гэлтгүй бүтээгдэхүүнээ экспортолдог бүх "айлд" тулгамддаг асуудал. Экспорт хийж буй компаниудын хувьд төрийн үйлчилгээг нэг цонхонд оруулах хэрэгтэй. Энэ байдлыг жилээс жилд хөнгөвчилөх зүйл ярьдаг ч шат дамжлаг улам хүндэрч байна. Монгол Улсаас экспортод бараа гарч байгаад хүн бүр баярлах ёстой. Манай улсад мөнгө орж ирж, ажлын байр бий болж, улсад татвар төлөх гээд нийгэм, эдийн засгийн хувьд өгөөжтэй. Үүнд хамгийн түрүүнд баярлах хүмүүс тэр мэргэжлийн хяналтынхан, төрийн байгууллагынхан баймаар. Бизнес эрхлэгчдийн төлсөн татвараар тэд цалинжиж байгаа шүү дээ. Төрийн байгууллагынханд үүнийг сайн ойлгуулж, чихийг нь зөөлрүүлэх хэрэгтэй байна. Өнөөдрийн нийгмийн сэтгэлгээг өөрчлөх шаардлагатай. Үйлдвэрт ажиллах хүн олдохгүй байна. Нийгмийн сэтгэлгээг өөрчилж, хүнлэг энэрэнгүй нийгмийг бий болгох цаг болжээ.

Бизнесийн дээрх философийг амьдралтайгаа хэрхэн уялдуулдаг вэ?

-Ерөнхийдөө адилхан. Ажлын бүх зүйл сайн, сайхан байх ёстой. Гэртээ ч

гэсэн тийм. Үр хүүхдээ сайн хүмүүжүүлж, мэдлэг боловсролтой болгоно. Ажил, амьдралыг адилхан хослуулж явна даа.

Та өөрийгөө хэдий үеэс бизнест туршлага суусан гэж үздэг вэ?

-2003 оноос л туршлагатай болсон гэж боддог доо. Харин 2006 оноос бизнесийн хүнд үеэ давчихлаа гэж бодсон. Тэрнээс хойш шантрахаар саад тогтор гайгүй болсон.

Эмэгтэй хүний хувьд, гурван хүүхдийн ээжийн хувьд энэ их ажлын хажуугаар ар гэрийнхээ ажлыг хэрхэн зохицуулж байна даа?

-Амралтын өдөр, ажлын цаг заваар бүх л зүйлийг зохицуулдаг. Анх хүүхдүүдийг маань ээж хардаг байсан бол одоо гэрийн үйлчлэгчтэйгээ хамжаад бүгдийг зохицуулж, амжуулна шүү дээ. Өнөөдрийн эдийн засгийн хүнд үеийг давж гарна. Гарах ч ёстой. Би найман хүүхэдтэй айлын ганц охин. Багаасаа гэрийнхээ бүх юмыг хийдэг байсан болохоор ажилч, шулуун шударга, арвич хямгач болж өссөн юм болов уу гэж боддог. Баянхонгор аймгийн Богд суманд эсгий гутал, хөвөнтэй дээл өмсөж өслөө. Тийм ч чинээлэг айлын хүүхэд байгаагүй. Тухайн үед одоогийнх шиг бэлэн зүйлс ховор байлаа. Саяхан охинтойгоо Монголын түүхийн музей үзэхэд цогийн индүү, нэхийний элдүүр зэрэг намайг бага байхад хэрэглэж байсан бүх зүйл музейд тавигдчихсан байсан. Тухайн үед хүмүүс хэрэглээгээр дутмаг байсан ч одоо үеэс илүү хүнлэг байсан гэж би боддог.

Үнэхээр хүнд хэцүү, шантарч байсан үеэ дурсахгүй юу?

-2007-2008 онд дэлхийн зах зээл дээр нэг кг самнасан ноолуурын үнэ 90 ам.доллараас 37 болж унасан. Тухайн үед маш их алдагдалд орж байлаа. Ер нь эрсдэлтэй үе их байдаг. Энэ салбарын гол түүхий эдийн зах зээл дээрх үнэ их савалгаатай. Энэ савалгаан дунд шантарч байсан үе зөндөө. Шантрах үедээ энэ бизнесийг болиод өөр юу ч хийхэв дээ гээд үргэлжлүүлээд хийж байсан. Энэ жил алдаж болно, дараа жил би олно гэсэн зарчмаар явсан. Энэ онд ноолуурын ханш буурах хандлага бий. Энэ удаагийн үнийн савалгаанд нэлээд туршлагатай, бэлтгэлтэй байна.

2014 оныхоо боловсруулсан ноолуураа экспортлоод дууссан.

Хэцүү үе бүрийг давах л ёстой гээд байх юм. Та их дайчин эмэгтэй бололтой.

-Ер нь би их эрч хүчтэй, дайчин. Энэ чанараараа амжилттай явж байна.

Нийгэмд эмэгтэйчүүдийн дуу хоолойг хүргэх тал дээр ямар бодолтой явдаг вэ?

-Би МҮХАҮТ-ын эмэгтэй бизнес эрхлэгчдийн Удирдах зөвлөлд байдаг. Дуу хоолойгоо байнга хүргэдэг. Хүмүүст хэлэх гэсэн үгээ шууд хэлчихдэг. Манайхан чи хэтэрхий шударга гээд байдаг юм, тэр хамаагүй ээ. Ер нь хүн дуугүй, бөөрөнхийлөөд байх биш, хэлэх гэснээ шууд хэлж байх хэрэгтэй гэж боддог. Хүн хэлээд байвал асуудлыг ойлгоно. Хэлэхгүй бол түүнийг анзаарахгүй, ойлгохгүй. Ойлгохыг ч хүсэхгүй. Энэ хүрээнд манай танхимын дэргэдэх эмэгтэй бизнес эрхлэгчид УИХ-ын эмэгтэй гишүүдтэй хамтарч ажиллаж байна. Бид эмэгтэй гишүүдтэй өглөөний уулзалт хийж бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санал, дуу хоолойг хүргэж эхэлсэн.

Танай үйлдвэрийн ажилчдын хэдэн хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Тэднийг та хэрхэн дэмжиж ажилладаг вэ?

-Үйлдвэр маань 300-гаад ажилтантай. Нийт ажилчдын 80 хувь нь эмэгтэй. Одоо цагт эмэгтэйчүүд л ажил хийдэг болж. Эрэгтэй хүн ажил хийхээ байж,

цалин нь буухаар хэдэн өдөр архидаад алга болж байна. Заавал яг эмэгтэй гэлтгүй, бүх ажилтнаа аль болох тогтвор суурьшилтай ажиллуулах тал дээр анхаардаг. Манай компанийн анхны ажилчид тэтгэвэртээ гарч эхэлж байна. Бид ажилчиддаа боломжийн, хүүгүй зээл өгдөг. Орон сууц худалдан авахад нь тусалж, дэмжих зэргээр амьдралд нь туслахуйц янз бүрийн хөшүүрэг хийдэг. Ямар нэгэн хөшүүрэггүйгээр ажилчид тогтвортой байна гэдэг асуудалтай.

-Ажилчдаа тогтвортой ажиллуулахад дэмжлэгийн гар сунгахаас гадна, таны удирдах чадвар нөлөөлдөг болов уу гэж бодож байна. Удирдах чадварын нууцаасаа хуваалцана уу?

-Манай ажилчид захиралдаа их хайртай. Би тэднийхээ ээж шиг нь хандаж ажилладаг. Тэд маань ч ямар нэгэн асуудал гарвал надад ханддаг. Ер нь эднийхээ асуудлыг аль болох шийдэж л явахыг хичээдэг. Тийм болохоор ч хүмүүс маань сэтгэлээсээ ажилладаг байх гэж боддог. Би ажилчиддаа нэг гэр бүл шиг байх ёстой гэж үргэлж хэлдэг. Байхгүй нэгийгээ нөхөөд ажилладаг. Би өөрөө маш их зарчимч, өндөр шаардлагатай. Миний хурдыг гүйцэхгүй, миний шаардлагыг хангаж чадахгүй хүнд би шууд хэлчихдэг. Ажилчид маань захирал их хурдан явдаг гэж хэлдэг. Нэг ажилчин маань "Захирлаа, би амралтынхаа өдрөөр нэг мэдсэн шогшчихсон, яараад явж байсан ш дээ" гэж байсан. Хурдтай



АНУ-ын Лас Вегас хотод болсон Аж үйлдвэрийн салбарын олон улсын хурал, 2015 оны хоёрдугаар сар

холбоотой хэлэхэд, Ерөнхийлөгч саяхан “Шилдэг татвар төлөгч ААН-үүдийн унааг хотын замын хөдөлгөөнд нэгдүгээр эгнээгээр зорчуулъя гэж байсан. Баялаг бүтээгчид нэгдүгээр эгнээгээр явах юм бол сайн л байна. Бизнесийн маань ажил хурдан шуурхай бүтээд байвал улс хөгжинө шүү дээ.

Та үйлдвэр дээрээ ч “шогшоод” явдаг байх нь ээ. Үйлдвэртээ долоо хоногт хэдэн удаа очдог вэ? Танай ажлын оффис их цэвэрхэн, цэгцтэй яг л эмэгтэй хүн удирдаж байна гээд хэлээд байх шиг. Үйлдвэр ч гэсэн адилхан биз.

-Долоо хоногт хоёр удаа очдог. Өдөр болгон гэхээр амждаггүй юм. Үйлдвэр маань их цэвэрхэн, эмх цэгцтэй. Бусад үйлдвэрийнхэн их очиж үздэг. Ер нь аливаа компанийн нүүр царай удирдлагаасаа их шалтгаалдаг. Би ажилчдыгаа оффист хоол идэхийг зөвшөөрдөггүй. Зочин ирэхэд хоол үнэртүүлээд сууж болохгүй. Бизнесийн соёл гэж бий.

“Ханбогд Кашимер” компанийн ноолуур угаах, самнах үйлдвэрийн хүчин чадал хэр вэ?

-Манай үйлдвэр нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ХХ хороонд байдаг. Жилд 1000-аад тонн ноолуур боловсруулах хүчин чадалтай. Үүнийг бүрэн боловсруулдаг. Тоног төхөөрөмжөө 2008 онд зуун хувь шинэчилсэн бөгөөд ноолуур угаах, самнах зориулалтын 100-гаад машин тоног төхөөрөмжтэй.

Та барилгын бизнестэй гэсэн. Тус салбарт эмэгтэй хүн бизнес эрхлэхэд хэр санагдав?

-Хоёр жилийн өмнө барилгын салбар руу орж 66 айлын орон сууц барьж, энэ онд ашиглалтад оруулсан. Мөн банк бус санхүүгийн байгууллага байгуулаад ажиллаж байна. Барилгын салбар их хүнд санагдсан. Энэ бол анхны болоод эцсийн барилга.

Ноолуурын бизнесээ эрхлээд явж байхад тулгамдаж буй асуудал юу байна вэ?

-Олон л асуудал байна. Гэхдээ даваад л гарч байна. Монголын нэр хүнд гадаад зах зээл дээр муудаж байгаа нь бидний хувьд хүндхэн цохилт. Улс ямар байхаас

бидний худалдаа, арилжаа шалтгаална.

Өнөөдрийн өндөрлөгөөс харахад анх таны бизнест хөл тавьж байсан үе хэр өөрчлөгдсөн бэ?

-Тэр үеэс одоогийн цаг үе, нөхцөл байдал хүнд байна. Улс орны хөгжлийн хувьд нэг их дээрдсэн зүйл алга. Анх бид бизнесээ амар амгалан хийж байсан бол одоо их стресстэй, энэ тэндхийн газарт очно ажил бүтэхгүй, аль болох л танил тал хайх хэрэгтэй болдог. Таньдаг, мэддэг хүнээр яриулж байж ажил бүтэж байна. Үнэхээр авлига, хээл хахуультай тэмцэх гээд байгаа юм бол өгсөнийг нь биш, авсан хүмүүсийг нь ялладаг байдлаар хуульд өөрчлөлт оруулвал авлигал багасах байх гэж бодож байна.

“ Монгол ноолуураар дэлхийн алдартай брэндүүдийг хийдэг учраас бид үйлдвэрлэлийн явц, чанартаа маш их анхаарч ажилладаг. ”

Татварын дэмжлэг ямаршуу байна вэ?

-Татварын дэмжлэг байхгүй ш дээ. Арав гаруй төрлийн татвар төлдөг. Эргээд төрөөс ямар нэгэн урамшуулал байдаггүй.

Хөнгөлөлттэй зээлүүдэд хамрагддаг уу?

-Өнгөрсөн жил л хамрагдсан. Тэр нь богино хугацааны буюу зургаан сарын хугацаатай зээл байсан. Хугацаанд нь эргүүлэн төлсөн.

Бизнес эрхлэгч залуу бүсгүйчүүдэд хандаж зөвлөгөө өгөхгүй юу?

-Шударга, зарчимч байж цаг хугацааг үр дүнтэй өнгөрүүлж байх ёстой. Хийж байгаа зүйлээ төлөвлөж, цаасан дээр буулгаж, биелүүлэхийн төлөө зүтгэдэг байх хэрэгтэй. Бизнес агаараар бодож, хийсвэр явж огт болохгүй. Хүн чаддаг зүйлээ л хийх хэрэгтэй. Өөр олон зүйл рүү сатаарах хэрэггүй. Жишээ

нь, самнасан ноолуураа дэлхийн стандартад нийцүүлэн сайн хийгээд, худалдаалах нь надад шулуун зам. Гэрээ хэлэлцээр нь гэрээ биш, цаас болчихдог хүнтэй гадаадынхан хэзээ ч хамтарч ажилладаггүй. Жишээлбэл, манай компани ноолуурын үнэ 50 ам.доллартай байхад гаднын нэг компанитай гэрээ хийсэн байлаа. Гэтэл ханш 80 ам.долларт хүрч өссөн. Тухайн үед гэрээ байгуулсан компанид 50 ам.доллараар ноолуураа худалдаалсан компани ганцхан манайх байсан. Ихэнх компани гэрээгээ цуцалсан. Харин би гэрээнийхээ үнээр ноолуураа өгсөн. Ингэснээр бид Европын зах зээлд нэр хүнд олж авсан. Хэдий надад их мөнгө харагдаж байлаа ч гэрээнийхээ дагуу л ажиллах ёстой.

Засгийн газраас дотоодын үйлвэрлэлийг дэмжинэ гэж байна. Үүнийг та хэрхэн харж байна вэ?

-Дэмжинэ гээд яриад байгаа. Хэзээ дэмжихийг нь мэдэхгүй. Бид дотоодын үйлдвэртэй хамтран ажиллахад НӨАТ хүртэл төлдөг. Жишээлбэл, “Говь” компани манайхаас тэрбум төгрөгийн бараа худалдан авлаа гэхэд би зуун сая төгрөгийн НӨАТ төлж байна. Бидний хамтын ажиллагааг НӨАТ-ын хууль боомилдог. Ерөнхийлөгчийн санаачилсан хуульд дотоодын үйлдвэрүүд хамтран ажиллахад НӨАТ-ыг тэг болгоно гэж байгаа. Мөн Аж үйлдвэрийн яамнаас авч хэрэгжүүлэх импортыг орлосон, экспортыг дэмжих бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих бодлого тэргүүтэй авууштай бодлого байна. Гэтэл энэ хууль хэзээ батлагдаж хэрэгжих нь тодорхойгүй. Тийм болохоор одоо яриад байгаа зүйлийг биелэж байна гэж хэлэхэд хүнд л байна.

Шударга хүн зарим хүнд ад үзэгдэх гээд байдаг тал ажиглагддаг. Таны хувьд арай ч дээ гэмээр үе байсан уу?

Заримдаа тийм тохиолдол гардаг.

Эцэст нь та улс орны хөгжилтэй холбоотой юу хэлэх вэ?

-Гуравхан сая иргэнтэй газар нутаг, ашигт малтмал байгалийн баялаг ихтэй манай улсын хувьд зөв бодлоготой хөгжлийн замыг тодорхойлж чадвал Сингапур улс шиг хөгжих боломжтой гэж боддог. ■



USAID
АМЕРИКИЙН АРД ТҮМНЭЭС



QSDC
БИД ТАНЫ БИЗНЕСИЙН АМЖИЛТАД
ХӨРӨНГӨ ОРУУЛНА

Ханган нийлүүлэгчдийн хөгжил, чанарын төв нь хувийн хэвшлийн төлөөллийн санаачилгаар АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-аас хэрэгжүүлж буй “Бизнесийг дэмжих санаачилга” төслийн дэмжлэгтэйгээр үүсгэн байгуулагдсан бизнес хөгжлийн байгууллага юм. Бидний зорилго дотоодын компаниудад борлуулалтаа нэмэгдүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг даван туулах, өсөн нэмэгдэж буй эрэлт, хэрэгцээг хангахад нь техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар тэдний өрсөлдөх чадварыг сайжруулахад оршино.

ХНХЧТ нь Техникийн туслалцааны сангаараа дамжуулан дотоодын аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй:

- Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- ISO, HACCP зэрэг олон улсын чанарын удирдлагын систем нэвтрүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах;
- Шинэ технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх;
- Илүү сайн ханган нийлүүлэгч олох;
- Худалдан авагчтай холбож өгөх
- Өнөөгийн ханган нийлүүлэгчээ хөгжүүлэх, нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг нь сайжруулах;
- Шинэ зах зээлд нэвтрэх зэрэг зорилгоо биелүүлэхэд нь санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлж байна.



**ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

ХНХЧТ-ийн “Ханган нийлүүлэгчийг хөгжүүлэх” хөтөлбөр нь:

- нэг талаас өөрийн ханган нийлүүлэгчдийн үйлчилгээний чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх хүсэлтэй худалдан авагч томоохон аж ахуйн нэгжүүд,
- нөгөө талаас өөрийн бизнесийг өргөжүүлэхээр эрмэлзэж буй жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйлчилдэг.

**ЧАНАРЫН УДИРДАГЫН
ХӨТӨЛБӨР**

ХНХЧТ нь компанийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн олон улсын шилдэг туршлагад суурилсан чанарын удирдлагын сургалтуудыг санал болгож байна. Манай байгууллага нь Лондонд төвтэй “Орчны эрүүл мэндийн итгэмжлэгдсэн институт”-ийн олон улсын гэрчилгээтэй дараах сургалтуудыг зохион байгуулж байна:

- Хүнсний аюулгүй байдал;
- Аюулын шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт (HACCP);
- Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал.

Түүнчлэн бид “Зургаан Сигма – Ногоон бүст мэргэжилтэн бэлтгэх” сургалтыг түншлэгч байгууллагатай хамтран зохион байгуулж байна.

Холбоо барих хаяг:
Экспрес цамхаг, 12 дугаар давхар,
Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: (976) 11-321375
Факс: (976) 11-327825
Вэб хуудас: www.qsdc.mn



**БИД ТАНЫ БИЗНЕСИЙН
АМЖИЛТАД ХӨРӨНГӨ
ОРУУЛНА**



Эрхээ хамгаалах өдрийн эргээд харах үр дүн

Иланд Роберт Манн
/“Mongolian Economy” сэтгүүлийн
Англи хэлний редактор/

Хөгшин Европын хүчин мөхөс эмэгтэйчүүд дуу хоолойгоо нэгтгэн эрхийнхээ төлөө хөл нийлүүлэн алхсан 1911 оны гуравдугаар сарын 19-ний тэр л өдрөөс хойш Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг өргөн дэлгэр тэмдэглэх болсон. Саналаа өгөх эрхгүй байсан европ эмэгтэйчүүд ажлын байран дахь хүйсийн ялгаварлал, төрийн албанд үүрэг, оролцоогоо нэмэрлэх “хүслийнхээ” төлөө тэмцсэний эцэст дуу хоолой, санал бодлоо дэлхий нийтэд түгээх эрхтэй болсон юм.

Монгол эмэгтэйчүүдийн хувьд сонгуульд оролцож, төрд ажиллах боломж бий ч нийгмийн олон давхаргад тэдний эрх зөрчигдсөөр буй. Зуу гаруй жилийн тэрээгээс өнөөг хүртэл эмэгтэйчүүд тэгш эрхийн төлөө тэмцсээр

байгаа билээ.

Төр ба тэгш эрх

Бизнес, улс төр, эдийн засаг гээд аль ч салбарт амжилттай явахын тулд эмэгтэйчүүд эрчүүдийн адил тэгш эрх эдэлж, тэнцүү “зиндаа”-гаар үнэлүүлэх ёстой. Энэ нь зөвхөн нийгэм гэлтгүй хувийн хэвшил, эдийн засаг, улс төрийг хүчирхэгжүүлдэг байна. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон “Хүчирхэг ардчиллын шинж чанар эрэгтэй, эмэгтэй гэх хүйсийн ялгаа үгүй, иргэддээ нээлтэй байж чаддаг зарчимд оршино. Эмэгтэйчүүдийн оролцоогүй ардчилал гэдэг нь жинхэнэ ардчиллын нэр томъёотой зөрчилдөж буй хэрэг” гэсэн байдаг.

Төрийн байгууллагад ажиллаж буй эмэгтэйчүүд жендерийн тэгш бус байдлын эсрэг манлайлан тэмцэж байна. АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Пайпер Кембэлл Америк төдийгүй Монголын эмэгтэйчүүдэд үлгэр дуурайлал болж буй хүчирхэг улс төрч эмэгтэй. Тэрбээр хэлэхдээ төр засгийн аль ч бүрэлдэхүүн хэсэгт эмэгтэйчүүдийн оролцоо их байх тусам нийгэм хүчирхэгддэг хэмээн өөрийн бодлоо бидэнтэй хуваалцсан. Элчин сайд “Үндэсний болон олон улсын түвшинд эмэгтэйчүүдийн дуу хоолой, үзэл бодол, эмэгтэй хүнийг төрийн үйлд оролцуулах асуудлыг чухалчлах болсон. Энэ нь бидний, эмэгтэйчүүдийн оролцоо ихээхэн ач холбогдолтой болохыг илтгэж байна” гэжээ.

Хэдийгээр эрх тэгшийн асуудал дэлхийн тулгамдсан сэдэв боловч нийгэмд оршин тогтносоор буй. Пайпер Кембэлл хэлэхдээ “Шийдвэрлэх ёстой асуудлууд олон байна. Жишээ нь, Ерөнхийлөгч Барак Обама “Нэгдсэн улсын байдал” илтгэлдээ хөдөлмөр эрхлэлт, цалингийн тал дээр хүйсээр ялгаварлахгүй байхыг дурьдсан бөгөөд тус улсын Хүүхдийн халамжийн хуулийн заалтуудыг сайжруулах, АНУ-д хүүхдийн тэтгэмжийг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлэх, мөн өвчтэй болон жирэмсний чөлөө авахтай холбоотой тэтгэмж зэрэг асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй” хэмээн онцолжээ. Эдгээр нь эмэгтэйчүүд ажлын байраа хадгалан үлдэх, хөдөлмөр эрхлэх байдалд томоохон нөлөө үзүүлдэг аж. АНУ-ын Засгийн газрын бүрэлдэхүүний ердөө 20 хувь нь л эмэгтэйчүүд байдгийг Элчин сайд Кембэлл хэлсэн юм. Монголын төрд эрэгтэй гишүүдийн тоо эмэгтэй гишүүдийнхээс хэд дахин илүү байдаг нь АНУ-ынхтай ижил түвшинд байна гэж болно. Гэсэн хэдий ч монгол эмэгтэйчүүдийн улс төрийн идэвх нэмэгдсээр буй. Тухайлбал, 2011 онд батлагдсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд ямар ч түвшний сонгуульд нэр дэвшигчдийн 25 хувь нь эмэгтэй байна хэмээн заасан. Хуулийн үр дүнд төрд эзлэх эмэгтэйчүүдийн “суудал” илүү олон болсон юм. Сүүлийн жилүүдэд гарсан хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд засаг захиргааны эрх мэдлийг аймаг, сумд нь хүлээлгэн өгсөн явдал орон нутагт эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо нэмэгдсэн, ингэснээр шийдвэр гаргалтад эмэгтэйчүүдийн үүрэг, нөлөө эрчимжиж байгааг холбогдох хүмүүс онцолж байгаа юм. Элчин сайд Кембэллийн үзэж буйгаар дээрх нь эмэгтэйчүүд дуу хоолойгоо хүргэх боломжийг нэмэгдүүлж байгаа аж. Гэвч улс төрд манлайлж буй эмэгтэйчүүдийн ард хүйсийн тэгш бус байдалтай тулгарсаар буй олон мянган эмэгтэй байна.

Монголын эмэгтэйчүүд ба хүүхдийн халамж

Элчин сайд Кембэлл өдөр бүр хэдэн арван монгол эмэгтэйтэй уулздаг. “Миний уулзаж байсан монгол эмэгтэйчүүд эрч хүч, хүсэл эрмэлзэл дүүрэн байдаг нь

надад үнэхээр гүн сэтгэгдэл үлдээдэг. Улс төр, бизнес гээд ер нь аль ч салбарт эмэгтэйчүүд дайчин, хурц байдаг нь ажиглагдсан. Тэд Монголын нүүр царай төдийгүй жинхэнэ төлөөлөл болж чадна гэж би итгэдэг” гэв. Ниймгийн бүхий л давхаргыг илэрхийлэх тэдгээр эмэгтэйд тулгардаг асуудлууд Элчин сайдын сэтгэлдээ тээн явдаг асуудлуудтай ижил болохыг тэрбээр анзаарчээ. Түүнд Монголын зэвсэгт хүчин, хилийн харуул болон цагдаа мэргэжилтэй эмэгтэйчүүдтэй уулзах завшаан олдсон тухайгаа ярихдаа “Би тэднээс “Та бүхэн эрчүүдтэй ижил боломж эдэлж чадаж байгаа юу? Та нар эрчүүдтэй ижил хэмжээний цалин авч чадаж байна уу?” гэж асуусан юм. Тэд төрд ажиллахын сайн тал нь эрэгтэй, эмэгтэй



гэж ялгалгүй цалингаа авдаг болохоор энэ тал дээр асуудал гардаггүй хэмээн хариулж байсан” гэсэн юм. Мөн тэрбээр “Гэвч тэдэнд тулгамддаг олон асуудал байдгийг ч олж мэдсэн. Яг л Ерөнхийлөгч Обамагийн онцлон ярьж байсан зүйлс Монголд ч байгааг харсан. Тухайлбал, албан тушаал ахих, хүүхдийн халамж, жирэмсний түр чөлөөлөх хугацаа авах зэргээс болж эмэгтэйчүүдийн хувьд ажлын байраа хадгалж үлдэх, тушаал дэвшихэд саад тулгардаг” хэмээн ярьж байлаа.

“Хүүхдийн халамжийн асуудлаар монгол эмэгтэйчүүд олонтаа ярих юм. Миний олж мэдсэнээр монгол гэр бүлийн харилцаа маш дотно байдаг. Эмээ, өвөө нар нь ач, зээгээ өсгөхөд гол үүрэг гүйцэтгэдэг. Харин хөдөө орон

нутгаас Улаанбаатарыг чиглэх шилжилт хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой зарим гэр бүл нэгнээсээ холдож хоорондын харилцаа хөндийрч байна. Үүнтэй холбоотойгоор миний хамгийн их сонсож байсан асуудал бол хүүхдийн халамж асаргаа, тэр дундаа цэцэрлэгийн асуудал түгээмэл байгааг анзаарсан. Тодруулбал, эмэгтэйчүүд хүүхдээ харахын тулд ажлаасаа гарсан эсвэл чөлөө авсан гэж ярьдаг. Энэ нь хүүхэдтэй болохоор шийдсэн гэр бүлийн аль нэг гишүүн, ихэнх тохиолдолд эмэгтэй хүн, ажлаасаа гарах, улмаар орлогогүй болж байна гэсэн үг” хэмээн хатагтай Кембэлл дэлгэрэнгүй тайлбарлсан.

Эдийн засаг ба эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт

Монголын “Космополитан” сэтгүүлийн ахлах редактораар ажиллаж байсан Б.Халиун 2014 оны арваннэгдүгээр сард Тайландын Банког хотноо болсон “Ази, Номхон далайн бүс нутаг, Бээжин +20”-ийн Хэвлэл мэдээллийн салбарын хүйсийн тэгш эрхийн байдал, хамгаалал сэдэвт НҮБ-ын Хүн амын сангаас зохион байгуулсан бага хуралд оролцжээ. Тэрбээр хуралд оролцсон сэтгэгдлээсээ хуваалцахдаа “Нүдийг минь нээсэн туршлага болсон. Ази, Номхон далайн бүс нутагтаа эмэгтэйчүүдийн эрхийн төлөө идэвхтэй тэмцэгчидтэй уулзах боломж олдож, Ази эмэгтэйчүүдэд тулгардаг нийтлэг асуудлуудын талаар сонсож мэдлээ. Үнэгүй ажил буюу хүүхэд, настан буурлууд, гэр бүлийнхнээ асрах нь эмэгтэйчүүдийн дунд, Монголын нийгэмд хамгийн түгээмэл байна. Энэ асуудал даамжирсаар нэг л мэдэхэд эмэгтэйчүүд эдийн засаг, улс төр, санхүүгийн хувьд эрчүүдээс хоцорч эхэлдэг. Үнэгүй ажил эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх, мэргэжлээ дээшлүүлэхэд саад болж байна” гэв.

Монгол эмэгтэйчүүд ажил эрхлэх, мэргэжлээ дээшлүүлэх боломж эрчүүдтэй харьцуулахад бага байдгаас үүдэн тэдний орлогын хэмжээ доогуур байдаг аж. Элчин сайд Кембэллийн хэлснээр Монголд эрэгтэй, эмэгтэй хүнд ногдох орлогын дундаж хэмжээ хол зөрүүтэй байгаа гэх. Түүнчлэн өрх толгойлсон эмэгтэйчүүдийн дийлэнхийн амьжиргааны түвшин ядуурлын

дунджаас доогуур байгааг тэрбээр хэлсэн. Нуруун дээрх “ачаа” нь хэдийнэ хүндэдсэн ч Монголын эмэгтэйчүүд гэр бүлийнхээ орлогын эх үүсвэр нь байсаар. Эдийн засаг хүндэрсээр байгаа энэ үед санхүүгийн чадавх сул эмэгтэйчүүд,

өртсөн байдаг. Монгол Улсад сүүлийн дөрвөн жилийн байдлаар 61 эмэгтэй, хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн золиос болж амь насаа алдсан гэсэн тоо бий. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийг УИХ-д өргөн барьсан. Хэрэв батлагдвал

харьцуулахад Монголын боловсролын түвшин дээгүүрт ордог. Хатагтай Кембэлл “Монголын боловсролын түвшин ерөнхийдөө маш сайн. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс боловсролын хувьд бараг ижил хэмжээнд байдаг. Энэ нь жендерийн эрх тэгш байдлыг тогтоох гол тулгуур цэг болох юм. Боловсролын насны буюу 7-22 насны эрэгтэйчүүдийн 75.5 хувь, эмэгтэйчүүдийн 82.2 хувь нь суралцаж байгаа нь үнэхээр гайхалтай тоо. Монгол Улсын хөгжилд хүрэх зам нь өөдрөг байна гэсэн эерэг дүгнэлтэд хүрч болохоор байна” хэмээжээ. Гэвч дээрх эерэг үзүүлэлт хот суурин газарт л биелэх боломжтой байгаа аж. Малчин бүсгүйчүүдийн хувьд гэвэл боловсролд хамрагдах нь хязгаарлагдмал байдгаас гадна мэдээлэлд нэвтрэх боломжгүй зэргээс үүдэн хүйсийн тэгш эрхийн талаар бодох нь бүү хэл сонсоогүй ч байх жишээтэй. Мэдлэгтэй, мэдээлэлтэй байна гэдэг эмэгтэйчүүд эрхээ бүрэн утгаар нь эдлэх хүслийг сэдэлжүүлэх чухал хүчин зүйл гэдгийг Элчин сайд Кембэлл хэлсэн юм.



НҮБ-ын Хүн амын сангаас зохион байгуулах болсон “Улбар шар” чуулган

тэдний гэр бүлд асуудал улам хэцүүдэж байгаа юм. Уг нь бол эмэгтэйчүүдээр хүч нэмэх нь Монголын эдийн засгийг хямралаас гаргах томоохон түлхэц. Гэвч тэдэнд шаардлагатай тусламж, дэмжлэг үгүйлэгдэж байгааг Кембэлл тайлбарлахдаа “Монголын эдийн засгийн өнөөгийн үзүүлэлтүүдээс харвал хүүхдийн халамжийн асуудал, эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах асуудалд анхаарал хандуулах шаардлага улам ихээр нэмэгдэж буйг ажиглаж болохоор байна” гэсэн юм.

Гэр бүлийн хүчирхийлэл ба Монгол

Сонин, хэвлэлийн хуудаснаа түгээмэл харагдах болсон гэр бүлийн хүчирхийлэл нийгмийг айдаст автуулсаар. Гэсэн ч чимээгүй дайн гэгдэх гэр бүлийн хүчирхийллийн золиос болсоор буй олон мянган эмэгтэй “нууц”-аа өөртөө л үлдээдэг байна. НҮБ-ын Хүн амын сангийн Монгол дахь төлөөлөгч Наоми Китахара гэр бүлийн хүчирхийллийн талаар “Манай сангийн тооцоогоор дэлхийн төдийгүй Монголын эмэгтэйчүүд, охидын 35 хувь нь бие махбодийн эсвэл бэлгийн дарамтад тодорхой хэмжээгээр

энэ төрлийн үйлдлийг гэмт хэрэг гэж үзэн хохирогчдыг хамгаалахад асар том дэмжлэг болох юм” хэмээн онцлов.

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдлэгийг түгээх бас тэмцэхийн тулд НҮБ-аас “Orange Sessions” чуулганыг өнгөрсөн оны зургаадугаар сараас эхлэн зохион байгуулж буй. Төлөөлөгч Китахарагийн хэлснээр тус чуулганы зорилго хүчирхийллийг зогсоох, түүний талаар мэдлэг, мэдээллийг олон нийтэд таниулах, түгээхэд чиглэж байгаа аж. “Эмэгтэйчүүд, охидын хүчирхийллийн эсрэг нэгдэцгээе” хэмээх НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мунийн уриан дор үйл ажиллагаагаа явуулж буй тус баг өдгөө хүчирхийллийн эсрэг амьд тоглолт хийснээс гадна найман видео бичлэг хийн олон нийтийн сүлжээ, “YOUTUBE” сайтад байршуулаад байгаа юм байна. Монголд сар бүрийн 25-ны өдрийг гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл түгээх өдөр болгон “Улбар шар өдөр” хэмээн зарласан байна.

Боловсрол ба мэдээлэлд нэвтрэх боломж

Хөгжиж буй бусад оронтой

Үлдээх мессеж

“Монгол Улс Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн уламжлал болгон тэмдэглэдэг нь надад сайхан санагддаг. Монгол эмэгтэйчүүд маш зоримог, өндөр боловсролтой, түүхээс улбаалсан бие даасан сэтгэлгээтэй учир төр улсдаа чухал үүрэг гүйцэтгэдэг гэж би боддог. Тэдний өмнө өөдрөг ирээдүй гэрэлтэж байна. Бүгдэд нь сайн, сайхныг хүсье” хэмээх хатагтай ПайПер Кембэлл болон бидний яриа энэ хүрээд өндөрлөсөн юм.

Тус өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхээс гадна жендерийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн төрд эзлэх байр суурь, тэдэнд нийгэм болон хөдөлмөрийн салбарт боломж олгох, тэдний эдийн засаг, санхүүгийн чадавхыг сайжруулах, ингэснээр гэр бүлийн хүрээнд төдийгүй төр засгийн хэмжээнд хувь нэмрээ оруулах боломжийг нээлттэй болгох хэрэгтэй. Түүнчлэн эмэгтэйчүүдийн мэдээлэлд ойр байх нөхцөлийг бүрдүүлж, гэр бүлийн хүчирхийллийн биет гэрч болгохгүй байх асуудалд анхаарлаа хандуулан ажиллах бололцоо бидэнд бүрэн гэдгийг хүн бүр мартах учиргүй. ■

COAL MONGOLIA 2015

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 5 ДАХЬ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН



ANNIVERSARY

ЗАСГИЙН ГАЗРЫН
ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР:



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



УУРХАЙТАЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ



www.coalmongolia.mn, +976-70115590



БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА



УУРХАЙТАЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛЫН ХӨТӨЛБӨР

- 07:00 Чингис Хаан ОУ-ын нисэх буудалд ирэх
- 07:30 Чингис Хаан ОУ-ын нисэх буудал дээр бүртгэл явагдана
- 09:00 Улаанбаатараас нисэх
- 10:15 Таван Толгой / Ухаа Худаг-т буух
- 10:30 Хөдөлмөр хамгаалалтай танилцах (өглөөний цай)
- 11:00 Ухаа Худаг орд дээр зочлох (уурхай, үйлдвэртэй танилцах, цахилгаан станц, усны систем, Цэций дэх орон сууцны цогцолбортой танилцах гэх мэт)
- 13:30 Галлерей камп дээр өдрийн хоолонд орох
- 14:30 Таван Толгой уурхайтай танилцах
- 16:10 Таван Толгой нисэх буудал дээр ирэх
- 17:00 Улаанбаатар хот руу нисэх
- 18:30 Улаанбаатар хотод ирэх



Төсвийн орлогод үзүүлэх хувь хамгийн доод хэмжээнд хүрнэ

А.Бүрэнжаргал

Нүүрсний салбараас хамаарах төсвийн орлого жил ирэх тусам буурч байгаа. Үүнийг 2015 онд уул уурхайн салбарын орлогын 16 хувийг бүрдүүлнэ гэх хандлага харуулж байгаа юм. Түүнчлэн уул уурхайн салбарын чанаргүй зээлийн хэмжээ хамгийн өндөр байгаа нь тус салбарын дүр төрхийг илтгэж байна.

Уул уурхайн салбарын хөгжил Монголын эдийн засгийн ирээдүйтэй шууд холбоотой оршдог. Ийм ч учраас эдийн засгийн хөдөлгөгч салбарынхаа өнгөрсөн ба ирээдүйг хэлэлцэхээр “Эрдэс баялаг 2025” чуулганыг жил бүр зохион байгуулдаг. Энэ оны чуулганаар салбарт нөлөөлөх чухал сэдвүүдийг холбогдох эрхмүүд цохон тэмдэглэсэн. Тэр дундаа “Эрдэс баялгийн салбараас Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөө” сэдвийн хүрээнд манай улсын төдийгүй олон улсын хэмжээнд уул уурхайн экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний эрэлт болон ханшийн уналт сөрөг үр дагавар авчирч буйг чухалчилсан. Түүнчлэн хөрөнгө оруулалтын орчин тодорхой бус байгаагаас үүдэн гадаадын хөрөнгө оруулалт буурсан хэдий ч Монгол Улсын эдийн засаг долоо орчим хувийн өсөлттэй

гарсан нь тус салбарын ач холбогдол өндөр хэвээр байгааг харууллаа.

Манай улсын эдийн засагт дэмжлэг болох томоохон төслүүд хэлэлцээрийн шатанд яваа. Оюутолгойн далд уурхайн хөрөнгө оруулалт гацсан, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажил өнөөг хүртэл хөрсөнд буугаагүй зэргээс шалтгаалан гадаадын шууд хөрөнгө оруулалт тасралтгүй буурсаар өнгөрсөн оны гүйцэтгэлийн дүнгээр 644 сая ам.долларт хүрч уруудсан нь 2013 оны мөн үеийнхтэй харьцуулахад 3.3 дахин багассан тоо гэдгийг Сангийн яамнаас мэдээлсэн.

Гадаад худалдааны өнгөрсөн оны тоон мэдээллээс үзвэл экспортын тэргүүлэгч есөн бүтээгдэхүүнээс ямааны ноолуураас бусад бүтээгдэхүүн уул уурхайн салбарт хамаарах төдийгүй экспортын 90 гаруй хувийг бүрдүүлжээ. Энэ нь Монгол Улс уул уурхайн бүтээгдэхүүн, үнийн өөрчлөлтөөс хэт хамааралтай болохыг харуулж байгаа юм. Мөн 2010 онд дэлхийн зах зээл дээрх эрдэсийн бүтээгдэхүүний ханш огцом өссөн явдал уул уурхайн салбараас төвлөрөх нийт орлогын хэмжээг 874 тэрбум төгрөгт хүргэсэн. Улмаар нэгдсэн төсвийн нийт орлогын

28 хувийг бүрдүүлсэн нь сүүлийн таван жилд гарсан хамгийн өндөр үзүүлэлт болсон. Өдгөө тус салбарын орлогын төсөвт эзлэх хувь тогтмол буурсаар өнгөрсөн оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 18 хувьд хүрснийг “Эрдэс баялаг 2025” хэлэлцүүлгийн үеэр Сангийн яамны эдийн засгийн бодлогын газрын макро эдийн засгийн бодлогын хэлтсийн дарга Г.Батхүрэл хэлсэн.

Нүүрс, зэс, төмрийн хүдрийн ханш уруудаж байгаагаас шалтгаалан уул уурхайн салбарын орлого 852 тэрбум төгрөг болж буурах, цаашлаад төсвийн орлогын ердөө 13 хувийг эзлэнэ гэсэн тооцоо гарчээ. Ингэснээр төсвийн орлогод үзүүлэх хувь хэмжээ сүүлийн таван жилийн хамгийн доод үзүүлэлтэд хүрэх аж. Зэсийн салбараас төсөвт төвлөрөх орлого уул уурхайн салбарын нийт орлогын 40-60 хувийг бүрдүүлж ирсэн. Уул уурхайн салбарын бусад бүтээгдэхүүний үнийн бууралт болон Оюутолгойн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж байгаа тул 2014-2015 онд уул уурхайн нийт орлогын 60 орчим хувийг зэсийн салбар дангаар бүрдүүлэх төлөвтэй байгааг мэргэжилтнүүд онцолсон. ■

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН НӨЛӨӨ



3.5%

Бусад ашигт малтмал



5.6%

Газрын тос




Уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлт 2013 онд

16.4% Нүүрс



24.8%

Металлын хүдэр



2013 оны байдлаар манай улсын нийт зээл авсан аж ахуйн нэгжийн 9.7 хувийг уул уурхайн салбарынхан эзэлж байгаа бөгөөд үүний 31.6 хувийг чанаргүй зээл эзэлж байна.


Уул уурхайн оргил үе гэгдэж байсан 2011 онд тус салбарын улсын төсөвт төвлөрүүлсэн

хөрөнгийн **39** хувийг нүүрсний салбар эзэлж байсан бол энэ онд

16 хувийг бүрдүүлэх таамаг байна



2014



Харин зэсийн салбараас 2011 онд уул уурхайн улсын төсөвт төвлөрүүлсэн хөрөнгийн

42 хувийг эзэлж байсан

бол энэ онд **59** хувийг бүрдүүлэх хандлага ажиглагдаж байна



Томилгоо

“Эрдэнэс Монгол”-ын шинэ удирдлагыг юу хүлээж байна вэ?



Д.Бэхээ

Б.Бямбасайхан захирал “Эрдэнэс Монгол” хэмээх нийтийн өмчийн компанийг удирдах үүрэг хүлээв. Түүний хувьд аж ахуйн нэгжийг удирдах арвин туршлагатай. Мөн эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалт, зах зээлийн өндөр мэдлэгтэй нэгэн.

Тэрбээр МУИС болон АНУ-ын Жорж Вашингтоны их сургуулийг төгсөөд Америк, Азид 10 гаруй жил ажиллаж амьдраад 2010 онд эх орондоо ирж, “Клин Энержи” компанийн захирал, удалгүй “Ньюком” компанийн гүйцэтгэх захирал болсон юм. Тэрбээр Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний хөгжилд том хувь нэмэр оруулсан 50 МВт-ын Салхин станцын хөрөнгө оруулалт 120 гаруй сая ам. долларыг босгоход өөрийн мэргэжлийн ур чадвар, мэдлэгээ жинхэнэ утгаар гаргасан билээ. Төвийн эрчим хүчний сүлжээнд анхны хувийн өмчийн станцыг барьж ашиглалтад оруулсан гэсэн үг.

Мөн дэлхийн технологийн аварга

гэгддэг “Женерал Электрик” компанийг Монголд оруулж ирсэн хүн бол Б.Бямбасайхан. Тус компани өнөөдөр “Ньюком”-ын сэргээгдэх эрчим хүчний хэд хэдэн төсөл дээр хөрөнгө оруулагчаар ажиллаж байна. Түүнчлэн Монголын нар, салхины нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулж, Ази руу экспортлоход чиглэсэн томоохон ажлуудыг эхлүүлснийг нь хэлэх хэрэгтэй. Тухайлбал, Японы “Софт” банктай хамтран Наран улс руу ногоон эрчим хүч нийлүүлэх судалгаа шинжилгээ хийх зорилготой “Клин Энержи Ази” компанийг байгуулсан. Мөн Азийн эрчмийн сүлжээ хөтөлбөрийг санаачлан Япон, Солонгосын томоохон компани, мэргэжилтнүүдийг энэ сүлжээнд нэгтгэж чадсан юм.

Ер нь түүнийг эрчим хүчний салбаргүйгээр төсөөлөмгүй. Тухайлбал, 2004-2010 онуудад Азийн хөгжлийн банкны эрчим хүчний санхүүгийн мэргэжилтнээр ажиллаж, Казахстан, Киргизстан, Пакистан, Тажикстан болон

Узбекстанд салбар дамнасан төслийн багуудыг удирдан, хөрөнгө оруулалтын хэлцлүүдийг гардан удирдаж, зах зээлээс хөрөнгө мөнгө босгоход суралцсан байдаг. Мөн олон улсын банк, санхүүгийн байгууллага, экспорт зээлийн банкууд болон нүүрсхүчлийн хийн сангуудаар дамжуулж хөрөнгө босгох чиглэлээр туршлага хуримтлуулсан төслийн санхүүч юм.

Б.Бямбасайхан захирал “Монгол бол эрчим хүчний диваажин орон” гэж хэлэх дуртай. Нар, салхи, ус болон нүүрсний арвин баялаг нөөцийг зөв бодлого, менежментээр, орчин цагийн технологиор эдийн засгийн эргэлтэд оруулж гадагш экспортолсноор Монгол Улс хурдацтай хөгжинө, иргэд сайхан амьдрах бүрэн боломжтой гэж тэр үздэг.

Монгол Улсад уул уурхай, эрчим хүч, үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн төслүүдэд хамтран хөрөнгө оруулах болон хөгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг, хөрөнгө оруулалт, төслийн менежмент,



санхүүгийн зөвлөгөө өгдөг “Нова Терра” компанийг 2013 оноос үүсгэн байгуулан ажиллаж байна.

Тэрбээр олон сонгуульт ажилтай. Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, Монголын ногоон барилгын хүрээлэнгийн удирдах зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэд бүтцийн асуудал эрхэлсэн орон тооны бус зөвлөх гэх мэт. Өнгөрсөн жил дэлхийн залуу удирдагчаар шалгарсан. Дэлхийн эдийн засгийн форумаас шилдэг залуусыг эх орондоо хийж бүтээсэн ажил, амжилт, бүтээл, туршлага, хувь хүний нийгмийн хариуцлага, үр дүнг нь чухалчлан авч үзэж шалгаруулан дэлхийд зарладаг уламжлалтай. Эх орондоо бол “Next Stop”-ын 2012 оны эдийн засаг, бизнесийн салбарын оны шилдэг залуугаар тодорсон билээ.

Шинэ цагийн залуусын үлгэр дуурайл, өндөр мэдлэг боловсролтой, шилдэг менежер Б.Бямбасайхан захирлыг уул уурхайн томоохон компаниудыг нэгтгэдэг “Эрдэнэс Монгол” компанийг амжилттай удирдаж дараагийн шатанд буюу олон улсын зах зээлд гаргах

хүн гэж Засгийн газар томилсон болов уу. Түүнд амжилт хүсэхийн сацуу олон ажил түүнийг хүлээж байна.

“Эрдэнэс Монгол” нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг зуун хувь, “Оюу Толгой” ХХК-ийн 34, уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн 51, “Шивээ Овоо” ХХК-ийн 90, “Багануур” ХК-ийн 75 хувийг тус тус эзэмшдэг, эдгээр стратегийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үүрэг хүлээж ажилладаг компани.

Тэгэхээр шинэ удирдлагын хувьд Оюутолгойг хөдөлгөх, Тавантолгойн хэлэлцээрийг хурдавчлахад оюунаа чилээж ажиллах нь. Мөн нүүрс, зэс, замын төслүүд хэрэгжүүлэх, “Чалко”-гийн өрийг шийдвэрлэх, гадаадын томоохон биржүүд дээр стратегийн ордуудаар IPO

гаргах зэрэг ажил хүлээж байна.

Түүнчлэн “Эрдэнэс Монгол”-ыг Сингапурын “Темасек” корпорацийн загвараар явуулбал үр дүнтэй гэсэн чиг гарчихсан яваа. “Темасек”-ийн тухай тодруулбал, 30-аад жилийн өмнө Сингапурын 30 гаруй төрийн өмчит компаниуд нэгдэн “Темасек” корпорацийг байгуулж, төрийн оролцоогүй ажиллаж эхэлсэн түүхтэй. Корпораци ТУЗ-өө сонгоно, ТУЗ нь гүйцэтгэх захирлаа томилно, зах зээлийн зарчмаар л үйл ажиллагаа явуулна. Засгийн газрын зүгээс ногдол ашиг авах л зарчим үйлчилснээр 40-хөн жилийн дотор тус корпораци маш амжилттай ажиллаж, Сингапур улс өндөр хөгжилд хүрч, иргэд нь сайхан амьдрах боломжтой болсон билээ. Нийтийн өмчит компани төрийн оролцоогүй болоод ирэнгүүт үр дүн гардгийн дэлхий дэх хамгийн сайн жишээ “Темасек” юм.

“Эрдэнэс Монгол” нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг зуун хувь, “Оюу Толгой” ХХК-ийн 34, уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн 51, “Шивээ Овоо” ХХК-ийн 90, “Багануур” ХК-ийн 75 хувийг тус тус эзэмшдэг, эдгээр стратегийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үүрэг хүлээж ажилладаг компани.

Энэхүү сайн загварыг Монголд жинхэнэ утгаар нь нэвтрүүлж, хэрэгжүүлж чадвал үр дүн ойрхон байгааг дээрх жишээ харуулна. Гэхдээ “Темасек”-ийн загварт хүрэхийн тулд маш их өөрчлөлт, шинэчлэлт хийх, ажиллах шаардлагатай. Дор хаяж 10 шатны зай байна. “Эрдэнэс Монгол”-ын хувьд 1,5 дахь шатанд л яваа компани. Тэгэхээр шинэ захирлыг дээрх хөгжлийн загварыг Монголын хөрсөнд тохирсон байдлаар сайн буулгах том ажил хүлээж байна. Энгийнээр хэлбэл, тус компанийг дэлхийд өрсөлдөх чадвартай болгож, олон улсын стандартад нийцсэн өндөр чанарын бүтээгдэхүүнтэй, засаглалын хувьд зөв менежменттэйгээр хөгжүүлэхэд бодлогоо чиглүүлж ажиллах ёстой.

Дараагийн нэг том асуудал бол Засгийн газар, улс төрчидтэй хэл амаа ололцох нь хамгийн хүнд байж мэднэ. Монгол Улсын хувь заяаг шийдэх ордуудыг нэгтгэсэн нийтийн өмчит компани руу улс төрчид хэтэрхий оролцоноос өнгөрсөн хугацаанд багагүй хэл ам гарсан. Ажил нь дорвитой явахгүй байгааг мэргэжилтнүүд төр, улстөртэй холбон тайлбарладаг. Хэрвээ дээрх компаниуд 100 хувь хувийнх байсан бол өнөөдөр ажил нэлээд явчихсан байх нь ойлгомжтой. Тиймээс төр бүх зүйлийг мэддэг, төр бүх ордыг эзэмшилдээ авах гэж дайрдаг, төр бүх зүйлд оролцдог, шахааны бизнес хийх гэж улайрдаг байдалдаа анхаарах цаг ирснийг харуулна. Мөн намынхаа нэг нөхрийг захирлаар нь тавьчихаад араас нь дарамталж, шахааж, ажлыг нь хийлгэдэггүй байдалдаа цэг тавих шаардлагатай.

Нээлттэй нийгмийн хүрээлэнгийн судлаач Д.Байлхүү “Эрдэнэс МГЛ”-ын бодит үнэлгээ, засаглалыг сайжруулах чиглэлээр судалж, тусгайлсан зөвлөмжийг гаргаж, тус компанид өгчээ. “Эрдэнэс Монгол”-ын засаглалыг шинэчилж, хуульд заасны дагуу ажиллаж, тус компанийг тодорхой үр дүнд хүргэх зорилготойгоор шинэ удирдлагыг томилсон гэж ойлгож байгаа” хэмээн судлаач Д.Байлхүү ярьсан.

Б.Бямбасайхан захирал Монголын Бизнесийн зөвлөлийн олон гишүүн компанийн бизнесмэнийн санал бодлыг төрд хүргэх, эдийн засаг, бизнесийн салбарт гарах олон хууль тогтоомж дээр санаа оноо өгч ажиллаж ирсэн. Харин одоо нийтийн өмчийн компанид очиж, өөрийн мэдлэг, туршлага, чадвараа гаргах нь ээ. Зөв цагт, зөв хүнээ сонгосон гэж олон хүн хэлж байна. Учир нь “Эрдэнэс МГЛ”-д хөрөнгө санхүүгийн зах зээлийг мэддэг, хөрөнгө босгох чадвартай, туршлагатай, дэлхийг Монголтой холбох, эх орноо дэлхийд танилцуулах, хурдтай, хүчтэй, хэлтэй, мэдлэгтэй удирдлага хэрэгтэй байгаа нь харагддаг. ■

Хөгжихөөр илгээсэн мессеж хүссэн дүн авчирсангүй

Тэрэнс Эдвардс, *Ройтерс*
агентлагийн Улаанбаатар хот дахь
сэтгүүлч



Хуучны Зөвлөлтийн дагуул байсан Монгол Улс өдгөө дэлхийн хэмжээний тусгаар улс болжээ. Олон улсад ч Монголын төрийн шийдвэр чих тавин сонсохуйц хүлээлт үүсгэх болсныг тус улсад хэрэгжиж буй мега төслүүдийн урагшлах явц харуулж буй.

Саяхан Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг улсынхаа хөгжлийг хааш чиглүүлэх талаар иргэд дунд санал асуулга явуулсан билээ. Шинэлэг хэдий ч шийдэл дагуулах нь бүрхэг түүний эл аргыг монголчууд төдий л таатай хүлээж авсангүй. Тодруулбал, Монгол Улсад 3.3 сая үүрэн телефоны дугаар хэрэглээнд бий гэсэн статистик байна. Ашиглалтад буй дээрх дугаарын хэрэглэгчдийн дөнгөж 10.3 хувь санал асуулгад идэвхтэй оролцож сонголтоо тодотгосон хариу илгээжээ. Энэ нь Ерөнхий сайдын санаачилсан санал асуулгын үр дүнд иргэд итгэл хүлээлгэхгүй байгааг харуулсан явдал болов. Түүнчлэн иргэдийн төрд итгэх итгэл улам буурч буйг албан ёсны сонгуульд оролцох монголчуудын суларсаар буй оролцоо илтгэж байгаа юм. Тухайлбал, 2008 оны Парламентийн сонгуульд сонгуулийн насны нийт иргэдийн 74 хувь саналаа өгсөн бол 2012 онд энэ тоо 65 хувь болж буурсан байдаг. Харин 1998 онд иргэдийн 98 хувь нь сонгуульд оролцож саналаа өгч байжээ.

Мессежээр авсан санал асуулгад иргэд “Сонголт 1” буюу уул уурхайн салбараа сэргээж, томоохон төслүүдээ хөдөлгөх хувилбарыг түлхүү дэмжсэн. Энэ нь иргэдийн хувьд хоёрдугаар

сонголт болох бүсээ чангалж, хэрэглээгээ хянахаас илүү амар сонголт гэдэг нь мэдээж. Монгол Улсын Засгийн газар 2013-2014 оны хооронд 85 хувиар унаад буй гадаадын хөрөнгө оруулалтыг сэргээх асуудалд анхаарал хандуулан ажиллаж байгаа гэх. Тэгвэл дээрх санал асуулга эдийн засгийн бас нэгэн хүнд жилийг туулах магадлалтай Ч.Сайханбилэгийн Засгийн газарт чиг өгөх луужин болох учиртай байсан. Ийнхүү иргэдийнхээ шийдвэрийн дагуу Монголын төр хувийн хэвшилтэйгээ хамтран мега төслүүдээ үргэлжлүүлэхээр болж байгаа юм. Эдгээрийн дунд 5.4 тэрбум ам.доллараар хэмжигдэх Оюутолгойн зэсийн уурхайн өргөтгөлийн ажил багтаж буй.

Харамсалтай нь, санал асуулгад оролцсон иргэдийн тоо хүлээлж байсан дүн авчраагүй тул ач холбогдолгүй болсон гэж дүгнэх хүмүүс байна. Тухайлбал, маркетингийн чиглэлээр ажилдаг 23 настай З.Хулан хэлэхдээ “Энэ чинь мессеж шүү дээ. Энэ ямар ч хэрэггүй. Би үүнд найдахгүй байгаа учраас санал асуулгад оролцоогүй” гэжээ. Түүнчлэн нэгээс дээш гар утастай иргэд олон удаа санал илгээх боломжтой байсан нь эцсийн дүн бодит бус гарна гэх дүгнэлтэд хүргэж байгаа юм.

Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн санал асуулгын талаар 26 настай оффис менежер Э.Цэндмаа “Түүний санал асуулга явуулсан гол зорилго олон нийтийн саналыг мэдэх гэсэндээ биш, харин ажлаа итгэлтэйгээр хийх ямар нэг дэмжлэг хүссэнтэй холбоотой байсан гэж бодож байна. Учир нь түүний эдийн

засгаа сэргээх бодлогод шүүмжлэлтэй хандаж буй олон хүн бий” гэв.

Уул уурхайн салбарын удаашралтай холбоотой эдийн засгийн уналт нүүрлээд буй нь Ч.Сайханбилэгийн санал асуулга явуулсан гол шалтгаануудын нэг аж. Тухайлбал, 2011 онд 17.5 хувийн өсөлттэй байсан эдийн засаг энэ онд ердөө долоон хувийн таамгаар илэрхийлэгдэж байгаа юм (одоогийн байдлаар Монгол Улсын Засгийн газраас тодорхой статистик, шаардлагатай мэдээллийг гаргаагүй байна).

Хөрөнгө оруулалтыг түгжиж байсан хууль, дүрмээ Монголын Засгийн хасаж өөрчилсөн ч Оюутолгойтой холбоотой “Рио Тинто”-гийн асуудал цэгцрээгүй байгаа нь хөрөнгө оруулалтанд саад болсоор байна. Оюутолгой нь дэлхийн хамгийн том зэсийн ордуудын нэг юм.

“Рио Тинто” өөрийн охин компани болох “Turquoise Hill Resources”-ийн эзэмшлийн дагуу Оюутолгойн 66 хувийг эзэмшдэг бол Монголын Засгийн газар 34 хувийг эзэмшдэг.

Өнгөрсөн оны 31-ны байдлаар Оюутолгойн далд уурхайг барих дөрвөн тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын тов хоёр жилийн хугацаанд дөрөв дахь удаагаа хойшиллоо. Тус бүтээн байгуулалт Дэлхийн банкны Олон улсын санхүүгийн корпораци болон Европын Сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр бий болох юм.

Гэвч зээл олгохын тулд “Рио Тинто”, Монголын Засгийн газар хоорондын маргаан эцэслэгдсэн байх шаардлагатай билээ. ■

Экспортлогч топ 3 орон



Шинэ маркет

Хуучин хувцасны эцсийн зогсоол

Б.Үүрийнтуяа

Сайн үйлсэд хэмээн итгэж олон мянган хүн хуучин хувцасаа ядуу, буурай орнууд руу илгээхээр холбогдох байгууллагуудад хандивладаг. Гэвч саяхны нэгэн судлагаагаар хандив нэртэй хуучин хувцасны дийлэнх хувь гаднын орнууд руу экспортод гарч, 4.3 тэрбум ам.доллараар хэмжигдэх дэлхийн хэмжээний худалдааны нэг хэсэг болдог аж.

Хятад зэрэг үйлдвэрлэл хөгжсөн орнууд хямд бараа, бүтээгдэхүүнээр дэлхий нийтийг хангах болсон нь хүмүүсийн хэрэглээг төрөлжүүлж, хувцасны сонголтыг улам аривжуулсан. Энэ хэрээр хуучин хувцасны хэрэглээнээс гарах тоог олшируулж буй юм. Үүний нэг илрэл нь өдөр бүр нэмэгдэх хуучин хувцас тушаах цэгүүд аж.

Хандив нэртэй ч худалдаалагдах нь элбэг хуучин хувцасны зах зээлийг дэмжих хүмүүс бий. Хаягдал болсноос хэрэгтэй хүндээ очих нь зүй ёсных хэмээн тэд үздэг байна. Харин ихэнх хүн хандивласан хувцас нь ашиг олох зорилгоор экспортод гардаг гэдгийг мэддэггүй болохыг Лондонгийн Кингс Коллежийн доктор Андю Брукс хэлсэн

юм. Учир нь хандивын дэлгүүрүүдээс хуучин бараа худалдан авах нь харьцангуй бага тул гадагш экспортлох нь элбэг аж.

НҮБ-ын гаргасан тоогоор хуучин хувцасны экспортоор АНУ, Их Британи тэргүүлдэг байна. Тэдгээрийн гол хүлээн авагч орнуудад Польш, Гана, Пакистан болон Украин багтсан байна.

Лондонд байрлах “LMB” хэмээх бес бараа дахин боловсруулагч компанийн захирал Росс Барри “Манай ажилчид хувцас хандивлах цэгээс бараа цуглуулж, ангилан ялгасны дараагаар шалгуурт нийцсэн хувцаснуудыг сонгон авдаг. Ингээд байнгын үйлчлүүлэгч болох зүүн Европ болон Африкийн орнуудад хүргүүлдэг. Ингэснээр тухайн орны иргэд ч хямд хэрнээ загварлаг, чанартай хувцас эдэлж, хэрэглэх боломжтой болдог” гэжээ.

Андю Бруксийн судалгаагаар Пакистанд цагаан өнгийн цамц, даашинз эрэлттэй байдаг бол зүүн европчууд дулаан хувцас түлхүү сонирхдог байна. Тэгвэл богино өмд, нимгэн цамц Африк тивийг “зорих” нь түгээмэл аж. Түүнчлэн Бруксийн үзэж буйгаар барууны

орнуудаас ирж буй хуучин хувцас, зүүн Азиас нийлүүлэгдэх хямд өртөгтэй шинэ хувцасны урсгал олон орны дотоодын бес бараа үйлдвэрлэлийн салбарт сөрөг нөлөө үзүүлж байгаа юм. Тухайлбал, хуучин хувцасны экспортын гол хүлээн авагч болох Сахарын цөлийн орнуудын хувьд дотоодын бес барааны үйлдвэрлэлд тун хүнд тусаж буй. Мөн Кени, Малави, Нигери, Рванда зэрэг улсад 1980-аад оноос эхлэн хуучин хувцас дотоодын зах зээлд том байр суурь эзлэх болжээ. Уганда улсад гэхэд хувцас борлуулалтын 81 хувийг “хандивын” хувцас эзэлдэг болохыг Андю Брукс судалгаандаа өгүүлжээ. Түүнчлэн 1975-2000 оны хооронд Гана улсын оёдлын салбар ажиллах хүчнийхээ 80 хувийг цомхотгосон бол Нигерт 200 мянган нэхмэлчин ажилгүйчүүдийн эгнээнд элссэн харамсалтай тоо байна.

Хандив гэж өгсөн зүйлс нь наймаачдын гараар ордог болохыг олон нийтэд тайлбарлах нь ярвигтай асуудал. Хэдийгээр хандивын зүйлс борлуулдаг дэлгүүрүүдийн орлогын эх үүсвэр нь хуучин хувцас боловч худалдагч, худалдан авагч талуудын хооронд ил тод байдал дутмагаас ойлголцлын асуудлууд тулгардаг байна. Бруксийн үзэж байгаагаар ил тод байдалтай холбоотой асуудлыг шийдвэрлэх хүндрэлтэй бөгөөд хуучин хувцасны импорт тухайн орны хөгжилд саад болж байгаа аж. Түүний хэлснээр хандивын байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд “дэлгэх” цаг болжээ. ■

Ч.Мэргэн: Сорьсон боломж, өндөр хариуцлага



Фотог Б.Баянба-Очир

Б.Баяртогтох

“Эдийн засаг хямралтай гээд бид заавал хямрах албагүй” хэмээн өгүүлэх “Вагнер Ази Автомотив” компанийн гүйцэтгэх захирал Ч.Мэргэн энэ салбарт амжилттай яваа нэгэн. “Бизнесийг зөвхөн мөнгө олох хэрэгсэл гэж харахаас илүүтэй хүн төрөлхтний амьдралыг өөрчлөх зүйл” гэсэн Генри Фордын итгэл үнэмшилтэй санал нэгддэг, шинэ мянганы шилдэг залуусын төлөөлөлтэй уншигч таныг уулзуулж байна.

-Танай компани эдийн засгийн хүндрэлийг даван гарахын тулд ямар стратеги баримталж байгаа вэ?

-Өнгөрсөн он нэлээд аз сорьсон жил байлаа. Энэ жил ч мөн ялгаагүй сорилтын он болохоор байна. Бид үүнийг боломж гэж харж байна. Тиймээс ухаалаг, нэлээд шинэчлэл хийж, илүү үр өгөөжтэй ажиллаж байж даван гарна.

Амжилт гаргана гэхээр борлуулалт 20-30 хувиар өсөх тухай биш юм. Харин тогтвортой үйл ажиллагаа явуулах, хүний орон тоогоо хадгалах нь өөрөө амжилт. Эдийн засаг хүндрэлтэй байгаа үед хамгийн сайн ажиллаж байгаа хүмүүсээ авч үлдэх нь чухал. Чармайлт гаргаж, идэвх зүтгэлтэй ажиллаж буй хүмүүсээ удирдлагын хувьд зөв чигт ухаалаг жолоодох хэрэгтэй байдаг. Хамгийн түрүүнд хийж байгаа ажил бол цалингийн хэмжээг гүйцэтгэлтэй нь холбож өгсөн. Манайх үүнийг хагас жилийн өмнө эхлүүлсэн. Одоо маш ойлгомжтой, тодорхой болж байна. Тухайн сар, сарын гүйцэтгэл, түүний үр дүнг хардаг.

-Ажилчдынхаа хувь хүний хөгжилд хэрхэн анхаарч байна вэ?

-Цалин, урамшууллын системээ

шинэчилж, үүнд ажилтны хувь хүний хөгжлийн асуудлыг ч мөн оруулсан. Өөрийгөө хөгжүүлэх, мэргэшүүлэхэд байгууллага болон тухайн хувь хүн анхаарах шаардлагатай. Ийм хөшүүрэг байж ажилтан сэргэж, шинэчлэгдэж байдаг. Ажилчид маань манай хамгийн том хөрөнгө оруулалт болохоор суралцах, хөгжих боломжийг гаргаж өгдөг. Цалингаа нэмж чадахгүй ч гэсэн сургах бодлого барьж байна. Тиймээс сургалтын зардлыг танаагүй, харин ялимгүй нэмсэн. Үүссэн эдийн засгийн асуудалд аль болох нээлттэй хандаж, ухаалаг тоглолт хийх тийм л зорилготой ажиллаж байна.

-Танай компанийн хүний нөөцийн бодлогыг сонирхох гэсэн юм. Шинэ хүн аваад мэргэшүүлж байна уу эсвэл туршлагатай ажилтанг сонгодог уу?

-Миний удирдлага дор 60 гаруй хүн ажилладаг. Бидний хувьд нэн түрүүнд анхаардаг зүйл бол хүмүүсээ сэтгэл хангалуун ажиллуулах, идэвхтэй байлгах зорилготой. Компани таалагдсангүй гээд гарсан хүн байгаагүй. Харин өөр бусад ажил, амьдралын шаардлагаас болоод жилд 1-2 хүн орж гарах нь бий. Ер нь ажилтанг аль болох авч үлдэх, цаашдаа илүү хол замыг хамтдаа туулах үүднээс хүний нөөцийн асуудалд нэлээд ач холбогдол өгч ажилласан. Үр дүн нь ч одоо гараад эхэлсэн. Тухайлбал, өнгөрсөн онд нэг л хүн ажлаас гарсан байх жишээтэй. Гарсан хүн маань суралцах шаардлага үүссэн. Баг чухал, тэр тусмаа тогтвортой байх нь компанийн үнэ цэнийг нэмэгдүүлж байдаг. Ямар ч байсан бид энэ багаа өнгөрсөн онд хадгалж чадсан гэж хэлж болно. Гэхдээ "Ажлаас халагдаж байгаагүй захирал гэж байдаггүй" гэсэн үг байдаг. Манайх хүний нөөцийн чиглэлээр олон ажил авч хэрэгжүүлсэн талаар дээр дурьдсан. Үүний нэг нь шинэ ажилтанд зориулсан дасан зохицох хөтөлбөр гэж боловсруулсан.

-Баг чухал болохыг та онцлоо. Шинэ хүн бол эхэлж сургалтад суух уу?

-Манайд шинээр ажилд орсон хүн группын гурван өдрийн сургалтад эхэлж хамрагддаг. Дараа нь манай компанид / Вагнер Ази Автомотивд/ дасан зохицох 90 хоногийн хөтөлбөрт хамрагдана. Ингээд хөтөлбөрийн дагуу цаашдаа сургалт, ярилцлагад ороод явдаг. Өөрийн гэсэн томилогдсон зөвлөгчтэй болох бөгөөд хамрагдан сурах сургалт хичээлийн жагсаалтыг ч мөн хүлээн авна.

Тухайн бий болсон албан тушаалд хамгийн сайн мэргэшсэн хүнийг авахыг эрмэлзэж ажилладаг. Мөн тухайн хүнийг тодорхойлох боломжтой хүмүүстэй холбогдож нэмэлт асуултад хариулт авдаг. Энэ нь бараг судалгаа гэж ойлгож болно. Ажилчид өөрсдөө хөгжиж байх ёстой. Сурсан зүйлээ хэрэгжүүлж байх нь чухал. Манайд сургалтын форум гэж бий болсон. Энэ нь сургалтад хамрагдаад ирсэн бол хамт олон, хэлтэс, багийнхандаа танилцуулга хийж, мэдлэгээ улам баталгаажуулдаг. Зарим хэрэгтэй гэсэн зүйлээ нэвтрүүлэх, хэрэгжүүлэх талаар судалдаг.

-Шинэ ажилтнаас заавал асуудаг,

голлох үүрэгтэй ямар асуулт байдаг вэ?

-Асуултаас гадна миний хувьд боддог хэд хэдэн зүйл байдаг. Тухайн хүний хандлага их чухал. Хандлага нь сэтгэл, тэмүүлэл, тодорхой зорилго юм болов уу. Том компанийн хувьд ажлын байрны тодорхой соёл хэвшсэн байдаг. Байгууллагын хүмүүс бүгд нэг зорилготой байх ёстой. Ингэж амжилттай, үр бүтээлтэй ажиллана. Үндсэн зорилго адилхан байвал бүгдээрээ нэгдэж, нэг цул болно. Шинэ ажилтанд нээлттэй хандах, багийнхаа нэгэн гишүүн болгохын төлөө хамт олон гэж байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, шинэ хүнийг мохоож болохгүй, дэмжих, итгэл хүлээлгэх нь шилмэл арга.

-Та өөртөө ямар шаардлага тавьдаг вэ?

-Миний өөртөө тавьдаг зарчим бол бусдаас хүсдэг зарчим. Энэ бол үр дүн. Үр дүн өөрөө үзүүлэлт байдаг. Үр дүн, ялангуяа хямралын үед амархан ирэхгүй. Үр дүн гаргахын тулд хүн өөрийгөө хөгжүүлж, шинэлэг санааг санаачилан, хэрэгжүүлж, бүтээлч байх хэрэгтэй. Хүн өөрийгөө илүү сайн таньж, нээж чадвал бусдыг илүү сайн ойлгож амжилтанд хүрэх боломжтой.

-Их ажлын хажуугаар ном уншиж амжиж байна уу?

-Ном ажил, амьдрал, авч яваа бизнесийн маань нэг томоохон хөшүүрэг нь. Аль болох ном унших цаг өөртөө гаргаж байхыг боддог. Ном хүний ухааныг задалж, төлөвшүүлж, хөгжүүлж байдаг. Тэндээс хүн маш олон зүйлийг өөртөө авч, суралцаж болно. Хамгийн өгөөжтэй, өөртөө хийж буй хөрөнгө оруулалт бол ном унших тэр цаг. Хэчнээн завгүй, ажил ихтэй байсан ч хүн байнга ном уншиж, оюун бодлоо цэнэглэж байх хэрэгтэй. Аливаа зүйлд зорилго тавих юм бол шууд эхэл гэдэг. Зорилгоо тодорхойлж чадсан бол эхний алхамаа хийх ёстой. Номыг бол 4-5 цагийн дотор уншиж болох юм байна лээ. Долоо хоног бүр нэг ном уншаад байх боломжтой. Бид ном унших асуудлыг нүсэр ажил гэж хүлээж авдаг. Уншихгүй байгаагаа завгүй гэж өөртөө тайлбарладаг. Өглөө эрт ном унших бол хамгийн тохиромжтой цаг. Миний хувьд одоо бизнесийн шилдэг номуудын тойм уншиж байна.

-Компанийн нийгмийн хариуцлага гэдгийг та хэрхэн хүлээн авдаг вэ?

-Компани бол асар том хариуцлагатай нийгмийн нэгэн гишүүн байгууллага. Компани нь үүсгэн байгуулагчид, ажилчид, харилцагчид, болон олон нийтэд хариуцлагатай. Чадварлаг ажиллах хүчин бэлтгэх, хамгийн оновчтой шилдэг шийдлийг харилцагчиддаа хүргэх, байгууллагын үүсгэн байгуулагчдад хөрөнгө оруулалтын өгөөжийг нь өгөх, тайлан балансаа үнэн шударга хөтлөж татвараа цаг хугацаанд нь төлөх, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах, зарим төрийн бус байгууллага болон нийгэмд ээлтэй ажлыг зохион байгуулах, дэмжих хэмээн байгууллагын нийгмийн хариуцлага нь өргөн цар хүрээтэй.

-Эдийн засаг таагүй байна. Энэ нь иргэдийн амьдралын чанарт нөлөөлж эхэлсэн. Ийм үед төр ямар бодлого хэрэгжүүлэх ёстой юм бол. Та бидэнд бодлоо хуваалцана уу?

-Валютын ханшийн уналтаас болоод эдийн засаг улам эмзэг болж байна. Энэ үед Засгийн газраас нийгмийн чанартай зардлаа танах тухай нэг бус удаа ярьсан. Нэг талаар зөв боловч нөгөө талдаа асар их эрсдэл, ядуурал бий болгох сул талтайг бодолцох хэрэгтэй. Эдийн засгийн хүндрэлтэй үед дундаж орлоготой буюу тэр тусмаа түүнээс доогуур орлоготой өрхийн амьжиргааны түвшин эрс мууддаг. Тиймээс иргэн хүний хувьд төр зорилтот бүлэгт хандсан байдлаар нийгмийн бодлогоо үр бүтээлтэй, үр дүн нь шууд харагдахуйцаар хэрэгжүүлэх учиртай. Манайх эрүүл мэнд болон боловсролын салбарт ихээхэн анхаарах хэрэгтэй. Өмнөд Солонгос руу маш их хэмжээний валют урсгаж байна. Мөн боловсролын салбарт ч ялгаагүй. Улс бүрт л тухайн орны үлгэр жишээ болсон шилдэг сургууль, эрүүл мэндийн төв байдаг. Манайх ийм сайн сургууль, эмнэлэгтэй болох шаардлага, хүлээлт, эрэлт байна. Улс нам гэхгүйгээр мэдлэгтэй, ур чадвартай хүмүүсээ тогтвортой ажиллах нөхцөл боломжоор хангаж өгөх хэрэгтэй. Гүйцэтгэл муутай, ашиггүй зардлаа халах ёстой. Тогтвортой хөгжил улс орны хувьд хамгийн чухал байдаг. Мөн эрүүл, өрсөлдөөнт шударга зах зээл, тийм сайн бизнесийн орчныг бий болгоосой. Төр бодитой, эргээд баялаг болох, түүнийг бий болгох салбартаа хөрөнгө оруулалт

хийж, хөгжлийн чанараа сайжруулах нь үр дүнтэй. Гэхдээ судалгаа, тооцоо, үр ашигтай эсэхийг нэлээд сайн судалж байх хэрэгтэй. Манай улс илүү нээлттэй болох учиртай.

-Бизнесийн орчин сайжирсан уу?

-Сайжрах боломж их байна гэж харж байна. Сүүлийн жил гаруй хугацаанд, хяналт шалгалт аудит ихэсч байна. Түүнчлэн, салбарын тулгамдсан асуудлуудыг төрийн байгууллагууд түргэн шийдвэрлэж өгч чадахгүй байна.

Нэгэн жишээ хуваалцъя. 2013 оны нэгдүгээр сараас эхлэн шинэ автомашиныг заавал оношлогоонд оруул хэмээх шаардлагатай бид тулгарч буй. Өмнө нь үйлдвэрээс шууд ачигдсан, үйлдвэрийн баталгаат цоо шинэ тэргийг гааль нь хилээр нэвтрүүлсэн байхад ийнхүү шаардлага тавьдаггүй байсан. Харин одоо улсын дугааргүй мөн даатгалгүй /оношлогоонд ороогүй болохоор дугаар мөн даатгал авах боломжгүй/ автомашиныг замын хөтөлгөөнд орохыг албадан шаардаж буй нь асар том эд хөрөнгийн эрсдэл

дагуулдаг. Уг нь бол тэр оношлогооны байгууллага нь гаалиас өөрсдөө шаардлагатай мэдээллийг нэхээд авах боломжтой байх ёстой. Төрийн байгууллагууд хоорондоо илүү сайн уялдан харилцаа, хамтын ажиллагаатай байх хэрэгтэй нь энэ жишээнээс харагдаж буй болов уу.

Татвар төлөгчдөө дэмжих, өөрсдийн үйл ажиллагаагаа сайжруулахад төрийн байгууллагын мэргэжилтнүүд илүү сайн анхааран ажиллах шаардлагатай. Төрийн албан хаагчид, дарга мэргэжилтнүүдийн хариуцлагын систем бүтэц нь сайжрах хэрэгтэй юм болов уу хэмээн бодож байна. Ер нь бол татвар төлөгч бидний үйл ажиллагаанд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэн дэмжин ажиллавал бидний ажлын бүтээмж сайжрах боломжтой. Түүний дагуу бид эцсийн хэрэглэгчиддээ илүү сайн үйлчилгээ үзүүлэх боломжтой бөгөөд ашиг орлого нэмэгдвэл мэдээж улсад төлөх орлогын хэмжээ ч мөн даган өсөх боломжтой.

-Танай компани энэ оны бизнес

төлөвлөгөөгөө хэрхэн зурагласан бэ?

-Бидний хувьд мянга мянган харилцагч олох шаардлагагүй. Монголд жилд нийтдээ 30-40 мянган автомашин орж ирж байна. Эдийн засаг сайн байгаа үед бол арай өндөр тоо гарна. Өнөөгийн нөхцөлд бол байдал тийм ч сайн биш байна. Гэхдээ хямралтай гээд бид заавал хямрах албагүй. Хийж байгаа зүйлдээ бүтээлч байх ёстой. Манай компанийн хувьд сэлбэг засварын үйл ажиллагаагаа улам сайжруулах, шинэ харилцагчид олох, тэдэнд бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулах чиглэлд анхаарч ажиллана. Бүх зүйл хумигдаад, зардлаа хасаад байвал ахиж дэвших боломжгүй. Ажилчиддаа боломж олгоё гэвэл тэлж байх л хэрэгтэй.

-Та бизнесийг юутай зүйрлэдэг вэ?

-Бизнес бол сорьсон боломж, өндөр хариуцлага. ■

Компанийн засаглал

Хувьцаа эзэмшдэг бол хуралдаа суугаарай

Г.Мөнх-Эрдэнэ

/Хөрөнгө оруулалтын шинжээч Гаүли ҮЦК/

Монголын хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдал алгуур сайжирч байгаа ч олон улсын түвшинд хүрээгүй хэвээр байна. Энэ нь хөрөнгийн зах зээлд итгэх итгэл сулрахад хүчтэй нөлөөлдөг. Тэгвэл гадаадын томоохон биржүүдэд бүртгэлтэй хувьцаат компаниудын мэдээллийг зохицуулагч байгууллагаас, компаниас өөрөөс нь эсвэл санхүүгийн мэдээлэл, судалгааны байгууллагын цахим хуудсаас авах боломж бүрэн дүүрэн байдаг. Жишээ нь, АНУ-ын "Үнэт цаасны арилжааны хороо"-ны EDGAR/Electronic Data Gathering, Analysis, and Retrieval/ системд АНУ-ын

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд зохицуулалтын шаардлагын дагуу олон төрлийн чухал мэдээлэл, тайлангаа илгээдэг. Харин "Үнэт цаасны арилжааны хороо" нь зохицуулалтаар хүлээн зөвшөөрөгдсөн мэдээлэл, тайланг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийт үзэж болохоор зохион байгуулжээ. Ингэснээр мэдээллийн ил тод байдал эрс сайжирч, зах зээлд итгэх хөрөнгө оруулагчдын итгэл эрс өсдөг.

Дээрхээс гадна хувьцаат компаниуд өөрсдийн вэб сайтаараа дамжуулан санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа цаг тухай бүрт нь олон нийтэд

хүргэдэг. "IR" буюу "Investor Relations"-ийг хариуцсан алба эсвэл хүнийг томилж хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх ажлыг хариуцуулж байна. Үр дүнд нь тухайн компанид итгэх хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгддэг.

Мөн "Блүүмбэрг", "Ройтерс", "Маркет воч", "Сийкийн алфа" зэрэг санхүүгийн томоохон хэвлэл мэдээлэл, судалгааны байгууллага нь хөрөнгийн зах зээл, хувьцаат компаниудтай холбоотой мэдээллийг цаг тухай бүрт нь бүрэн гүйцэт хүргэх ажлыг дэвшилт технологи ашиглан гүйцэтгэж байна. Ингэснээр хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад шаардлагатай дийлэнх мэдээллээ цаг алдалгүй, хүч хөдөлмөр, зардал гаргалгүй авч чаддаг.

Мэдээллийг үнэн бодит, бүрэн гүйцэт хэлбэрээр ил тод болгож буй эдгээр суваг нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, шийдвэр гаргах процессийг хялбаршуулсаар байна. Үүний хэрээр арилжааны хэмжээ өсч, зах зээлийн хөрвөх чадвар сайжирдаг. Харин Монголын хувьд дээрх мэдээллийн сувгуудаас аль ч хангалттай түвшинд хүрч хөгжөөгүй.

Ийм нөхцөлд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ашиглах үнэн бодит, бүрэн гүйцэт мэдээлэл, судалгааг хэрхэн цуглуулах вэ гэдэг нь маш хүнд даалгавар юм.

Хувьцаа эзэмшигчдийн хурал бол мэдээлэл авах хамгийн оновчтой эх сурвалж.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4-д заасны дагуу хувьцаат компаниуд нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулах үүрэгтэй. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал бол хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай үнэн бодит, бүрэн гүйцэт, чухал мэдээллийг хамгийн бага зардлаар, богино хугацаанд авах суваг юм. Хэрэв та хувьцаанд хөрөнгө оруулсан, түүнийгээ өсгөхийг хүсч байгаа бол ээлжит хуралдаа заавал



суугаарай. Хуралд оролцсоноор хувьцааныхаа өнөөгийн ба ирээдүйн үнэ цэнийг бодитоор үнэлэх боломж бүрдэж оновчтой шийдвэр гаргаж чадна.

Эцэст нь хэлэхэд, хамгийн гол нь ЗӨВ АСУУЛТАА ЗӨВ ЦАГТ НЬ ЗӨВ ТАВИХ юм. ■

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ЗААВАЛ СУУХ ДӨРВӨН ШАЛТГААН

Өнгөрсөнийг үнэлэх, ирээдүйг төлөвлөх цаг

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн удирдлагууд өнгөрсөн жил ямар төлөвлөгөө тавьсан болоод бодит байдалд хэрхэн ажилласан тухай өөрсдийн дүгнэлтийг өгч, байр сууриа илэрхийлдэг. Ингэснээр хөрөнгө оруулагчид компанийн удирдлагуудыг зорьсондоо хүрсэн эсэхэд бодит дүгнэлт хийх боломжтой болно. Үүний дараа удирдлагууд ирэх жилийн төлөвлөгөөгөө танилцуулдаг. Эндээс тэдний төлөвлөгөөнд үндэслэн ханшийн таамаг хийх боломж гарч ирнэ. Хамгийн гол нь төлөвлөгөөнд тусгасан тоог ашиглахдаа өнгөрсөн жил зорьсондоо хүрч чадсан эсэхтэй зөв уялдуулан дүгнэлт хийх хэрэгтэй. Ингэж чадвал харьцангуй бодит таамаг хийнэ. Өнгөрсөн ба ирээдүйн холбоосыг бодитоор харах боломжийг ээлжит хурал танд олгоно.

Анхдагч эх сурвалж

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд компанийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагууд оролцдог. Энэ нь танд шийдвэр гаргах түвшиний хүмүүст өөрийн биеэр асуулт тавьж, хариултаа өөрсдөөс нь буюу анхдагч эх сурвалжаас, ямар нэг дамжуулагчгүйгээр, шууд авах боломжийг олгоно. Энэ утгаараа хамгийн үнэн бодит мэдээлэл авна гэсэн үг. Авсан мэдээлэлдээ

зөв анализ хийж чадвал оновчтой шийдвэр гаргаж чадна.

Бүрэн гүйцэт мэдээлэл

Ээлжит хуралд гүйцэтгэх захирал, санхүү эрхэлсэн захирал, үйлдвэрлэл хариуцсан захирал, маркетинг, борлуулалтын албаны захирал гэх мэт шийдвэр гаргах түвшний хүмүүс бүгд оролцдог. Эдгээр эрх бүхий хүмүүс нэг дор цуглах, тэднээс асуулт асуух боломжийг ээлжит хурал олгодгоороо бүрэн гүйцэт мэдээлэл авах боломж бүрддэг. Ийнхүү ээлжит хуралд оролцсоноор танд үнэн бодит, бүрэн гүйцэт мэдээлэл авах боломж нээгдэнэ.

Цаг бага зарцуулж, зардал хэмнэнэ

Монголын өнөөгийн нөхцөл байдалд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд суухгүйгээр үнэн бодит, бүрэн гүйцэт мэдээлэл цуглуулна гэдэг маш их цаг хугацаа, зардал гаргадаг ажил болдог. Мөн үр дүн нь ямар байхыг шууд таамаглах боломжгүй. Харин хуралд оролцсоноор цаг хугацаа, зардал хэмнэнэ. Үр дүн ч тодорхой болно.

Энэ жилийн ээлжит хурлын товууд зарлагдсаар байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов МХБ-ийн сайтад байршдаг. Та дараах линкээр орж үзнэ үү. <http://mse.mn/conf/list>

АРД ДААТГАЛ ХХК-ийн тухай

Ард Даатгал компанийн хувьд 1994 онд Монголын анхны хувийн даатгалын компани болж байгуулагдсан бөгөөд 2004 онд хөрөнгө, санхүүгийн зах зээл дээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Их Британийн “Виттингтон” групп тус компанид хөрөнгө оруулалт хийж хувь нийлүүлэгч болсноор “Ард Даатгал” компани нь улсдаа гадаадын хөрөнгө оруулалттай анхны даатгалын компани болж, Европын тэр тусмаа даатгалын зах зээл анхлан хөгжсөн Английн даатгалын зах зээлийн шилдэг туршлага, олон улсын know-how, бүтээлч чанарыг улс орныхоо даатгалын зах зээлд авчирсан юм.

Мөн 2011 оны эхний улиралд бид “Гранд Даатгал” ХХК-ийг албан ёсоор өөртөө нэгтгэсэн нь Монголын даатгалын зах зээл дээр бий болсон анхны нэгдэн нийлэх (merger & acquisition) процесс бөгөөд үүгээрээ даатгалын зах зээл дээр компаниуд нэгдэн нийлэх, өрсөлдөөны зөв орчин бүрдүүлэх зэрэг олон зөв хандлага, жишгийг зах зээлд бий болгосон билээ.

2012 онд манай томоохон харилцагч байгууллагын даатгуулсан үл хөдлөх хөрөнгө (агуулах), агуулах дахь бараа материалд гал гарч үлэмж хэмжээний хохирол учирсан бөгөөд уг хохирлын нөхөн төлбөрийг бид өнгөрсөн онд давхар даатгалын “Ханновер Ре” компаниас 100 хувь

гаргуулан өгч, улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш их хэмжээний хохирлыг давхар даагчаас төлүүлсэн анхны тохиолдол болсон бөгөөд мөнгөн дүнгээр 4.0 тэрбум гаруй төгрөгийн хохирлын нөхөн төлөлт юм. Энэ нь тус компани өөрсдийн авсан эрсдэлийг хэрхэн зөв хуваарилж дэлхийд нэр хүнд бүхий давхар даатгалын компаниудтай хамтран ажиллагдийг болон тухайн давхар даатгалын гэрээний үр өгөөжийг харуулсан хэрэг билээ.

“Ард Даатгал” компани нь 2011, 2012, 2013, 2014 онуудын жилийн эцсийн нийт хураамжийн орлогоороо Монголын даатгалын зах зээл дээр жил дараалан эхний гуравт жагсаж, нийт хураамжийн орлогыг нөхөн төлбөр болон давхар даатгалтай харьцуулсан дүнгээр, өөрөөр хэлбэл даатгалын үйлчилгээнээс харилцагч, даатгуулагчдаа өгсөн бодит өгөөжийн үр дүнгээр салбартаа тэргүүлэх байр суурьтай ажиллаж байна. Мөн компани нь өнгөрсөн оны үзүүлэлтээр ашигт ажиллагааны хувьд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа 17 компанийн нийт ашгийн 31 хувийг бүрдүүлж, энэ үзүүлэлтээр тэргүүлж байна.

2013 оны жилийн эцсээр манай компанийн томоохон хувьцаа эзэмшигч болох “Интергрупп Интернэйшнл”




ХХК нь “Ард Даатгал” компани дахь өөрийн эзэмшил хувьцаагаа “И Ай Ти” ХХК-ийн хувьцаагаар харилцан солилцох гэрээг байгуулсан бөгөөд ингэснээр “Ард Даатгал” ХХК-ийн шууд хөрөнгө оруулагчаар “Интергрупп Интернэйшнл” ХХК-ийн оронд “И Ай Ти” ХХК орж ирсэн юм.

Ингэснээр “И Ай Ти” ХХК-ийн шууд хөрөнгө оруулалт бүхий “Ард Даатгал” ХХК, “Ард Кредит” ХХК, “Ард Актив” ХХК, “Ард Секьюритес” ХХК зэрэг банк санхүү, даатгал, үнэт цаасны брокер, дилерийн компаниуд нь “Ард Санхүүгийн Нэгдэл” хэмээх хүчирхэг санхүүгийн үйлчилгээний группыг бий болгон, хэрэглэгч, харилцагчдаа улам бүр ойртон ажиллахыг зорьж байна.

“Ард Даатгал” компани нь Компанийн сайн засаглалын

зарчмуудыг хэрэгжүүлэх, санхүүгийн олон улсын тайлагналын зарчмын хэрэгжилтийг хангах, ил тод, нээлттэй байдлыг Компанийн үйл ажиллагааны бүхий л түвшинд нэвтрүүлэх үүднээс олон улсын нэр хүнд бүхий аудит, санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “PriceWaterhouseCoopers” аудитын компанитай зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан компанийн засаглал, ил тод байдал, Санхүү тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ийн чиглэлээр зөвлөгөө авч компанийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллалаа.

Мөн энэ ажлын үргэлжлэл болгон 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа олон улсын топ дөрвөн аудитын компанийн нэг болох BDO аудитын компаниар аудит хийлгэж байна. ■



Хил давсан гээд хамаагүй гэж болохгүй

Б.Баяртогтох

Та нэг бол Монгол Улсын иргэн, эс бол гадаад улсын иргэн. Манайд мөрдөгдөж буй өнөөгийн Харьяатын тухай хуульд “Монгол Улсын харьяат нэгэн зэрэг гадаад улсын харьяат байхыг хүлээн зөвшөөрөхгүй” хэмээн заасан. Даяарших тусам улам хөндөгдөх давхар иргэншлийн асуудлыг тодорхой болгох хууль эрх зүйн зохицуулалтын олон хэлбэр байж болох талаар Германд мэргэшил эзэмшсэн, хуульч Д.Үүрцайх ярьсан.

Дэлхийд давхар иргэншилтэй 30 гаруй улс байдаг. Зарим нь тухайлан улс орны нэр хүртэл заадаг байна. Харин манай улс дээрх асуудлаас дөлж, эмээсээр ирсэн гэж болно. Цаашдаа ч ийм байх вий гэсэн айдас гадаадад амьдарч буй элэг нэгт монголчуудад төрсөөр удав. Үүнээс болж харьд суугаа тэдний цөөнгүй нь тэндээ үлддэг. Сүүлийн жилүүдэд давхар иргэншлийн асуудлыг эрчимтэй хөндөх болсон. Гэвч улс төрийн дэмжлэг авалгүй, дарагдаад хоцордог. Давхар иргэншилтэй болчихвол Монгол Улс даруй гурван сая хүнээр хэмжигдэхгүй өнөр олуулаа болох юм.

Гадаадад 100 гаруй мянган монголчууд ажиллаж, амьдарч байна гэсэн албан бус тоо бий. Тэгэхээр 100 мянгаас ч олон монгол иргэн харийн нутагт явна. Хэрэв төдий тооны монгол хүн гадаад улсад байгаа гэвэл манай улсын нийт хүн амын 3-4 хувь нь хилийн чанадад сууна. Одоогоор 15 мянган иргэн өөр улсынх болох хүсэлтээ гаргаад буй аж.

Гадаадад амьдарч буй монголчууд давхар иргэншлийн асуудлыг чимээ анирлан суудаг гэхэд дэгсдэхгүй. Тэдний хүсэл хэрхэх нь өнөө хүртэл таамаг төдий. Монгол хүн Монголын баялаг. Эх орондоо ирэх сэтгэл хэдий

байвч үр хүүхэд, тэдний өссөн орчин, ирээдүйн талаар эргэцүүлж бодох шаардлага тулгардаг тухай гадаадад буй монголчууд өгүүлдэг. Тухайлбал, өөр орны харьяалалд бүртгэлтэй монгол хүүхэд эх орныхоо иргэн нь болох гэхээр төрсөн бүртгэлтэй орныхоо иргэншлээс татгалзах шаардлага гарч буйг тэд учирладаг. Жишээлбэл, өөр улсын иргэн болчихсон монгол иргэн нутаг буцахын тулд Монгол Улсын виз хүсэх нь энгийн үзэгдэл болжээ.

Давхар иргэншлийн асуудал орхиж үл болох сэдэв. Тодруулбал, АНУ-д жилд дунджаар 500 орчим монгол хүүхэд шинээр төрж, мөн тооны монгол иргэн гаднын иргэдтэй гэр бүл болж, улмаар манай улсын цөөнгүй иргэн амьдарч буй тухайн улсынхаа иргэн болдог. Тэгвэл Өмнөд Солонгост амьдарч буй Монголчуудын холбооноос гаргасан судалгаагаар таван хүн тутмын гурав нь давхар иргэншил нэн чухал байгааг онцолжээ.

Монголчууд хамгийн их ажиллаж, амьдарч буй БНСУ, АНУ-д давхар иргэншил хүсэх бүхэл бүтэн үе өсөн бойжиж байна. Ихэнх улсад гадаад иргэнийг өөрийн орны иргэн болгох зөвшөөрөл өгөхдөө тухайн улсынхаа харьяатаас заавал гарах ёстой гэсэн хатуу шаардлага тавьдаггүй. Тэр тусмаа ардчилсан нийгэмтэй, хөгжиж буй чөлөөт эдийн засагтай орнуудад энэ чиглэлд харьцангуй нээлттэй ханддаг аж. Манай улсын хувьд Монгол Улсын иргэн хязгаарлагдмал хүрээнд давхар харьяалалтай болох тухай хуулийн төслийг 2005 оноос эхлээд ярьж байгаа. Гэвч өнөөг хүртэл сунжирсаар байна.

Давхар иргэншил нь Үндсэн хуулийн заалтыг хөндөх тул УИХ, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцэх

хэмжээнд асуудал өрнүүлэх нь мэдээж. “Цахим өртөө” төрийн бус байгууллагын тэргүүн Д.Цэрэнбат “Манайх өндөр хөгжилтэй зарим оронтой давхар харьяаллыг харилцан хүлээн зөвшөөрч шийдвэрлэх, давхар харьяалалтай Монгол Улсын иргэний эрхийг тодорхой хугацаагаар хадгалдаг журам хэрэгжүүлэх шаардлага байгаа” гэв. Үүнээс гадна эргэж Монгол Улсын иргэн болох нөхцлийг хялбаршуулах, улмаар давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөх, өөрийн болон Монголд иргэншлээр хүсэлт гаргаж байгаа гадаадын иргэдийн эрх ашгийг нийтэд нь, жигд хамарсан эрх зүйн орчин бүрдүүлэх хэрэгтэй байгааг өнгөрсөн онд Улаанбаатар хотноо болсон “Хилийн чанад дахь монголчуудын чуулга уулзалт”-ын үеэр хэлцгээж байсан юм.

Дээрх асуудлаар Гадаад хэргийн яамнаас тодруулахад, Монгол Улсад үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу давхар иргэншлийг хүлээн зөвшөөрөх ямар ч бололцоогүй юм байна. Гэхдээ монгол иргэдээс төрсөн ч гадаадын иргэн болсон хүүхдүүд, гадаадын иргэн болсон монголчууд эх орондоо чөлөөтэй зорчих, ажиллах, хөрөнгө оруулах, хуулиар олгогдсон эрхээ эдлэх бололцоог олгосон “Ногоон картны систем” нэвтрүүлэх хууль эрх зүйн баримт бичиг боловсруулахаар ажиллаж байгаа аж.

Геополитикийн хувьд хоёр том хөршөөр хүрээлүүлсэн, газрын баялаг ихтэй, цөөн хүн амтай манай оронд дээрх харьяатын асуудлыг хүлээн зөвшөөрөх боломжгүйг дээр дурьдсан. Гэхдээ холбогдох хууль тогтоомжоо сайжруулах, эргэж харах шалтгаан нь харьд суугаа монголчууд гэдгийг мартаж үл болно. ■





MONGOLIA 2015
MINING
 INTERNATIONAL MINING & OIL EXPO

БУЯНТ УХАА СПОРТ ЦОГЦОЛБОР
2015 . 04 . 01 - 03

www.mongolia-mining.org

ОЛОН УЛСЫН УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОСНЫ ҮЗЭСГЭЛЭН
- 5 дахь удаагаа -



15 ОРНЫ 120 ҮЗЭСГЭЛЭН ГАРГАГЧИД

ДЭЛХИЙН ТЕХНОЛОГИ ДЭРТЭД ЦЭЛЭЭ

ТАЛБАЙН БҮРТГЭЛ

АМЖИЖ БҮРТГҮҮЛНЭ ҮҮ!

**Нийт талбайн 80%
 борлогдсон.**

ЗОЧНЫ БҮРТГЭЛ

ЗОЧИД www.mongolia-mining.org цахим хуудсаар үнэгүй бүртгүүлснээр дараах хонжвортой **АЗЫН СУГАЛААНД** оролцоно.

Үүнд:

- Канадад уул уурхайн сургалтад үнэгүй хамрагдах эрх
- Ивээн тэтгэгчдийн шагналууд

Хонжворыг үзэсгэлэнгийн хаалт дээр гардуулна.

☎ **976-11-344 488**

✉ info@mongolia-mining.org

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД



МЭДЭЭЛЛИЙН ТУНШ



ЗОХИОН БАГУУЛАГЧ



